



**НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР**

БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН-2022 ОН

**УЛААНБААТАР ХОТ
2022 он**

АГУУЛГА

ТАНИЛЦУУЛГА

- ✓ Танилцуулга
- ✓ Алсын хараа
- ✓ Эрхэм зорилго
- ✓ Үндсэн чиг үүрэг..... 2-3 хуудас

БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

- ✓ Бүтэц, зохион байгуулалт 4 хуудас

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

- ✓ Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн
- ✓ Хууль тогтоомж, тогтоолын шийдвэрийн хэрэгжилт, үр дүн 5-7 хуудас

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН

- ✓ Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт
- ✓ Газрын дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилт
- ✓ Дотоодын болон өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх ажил, арга хэмжээ
- ✓ Хууль тогтоомжид заасан бусад ажил, арга хэмжээ
- ✓ Хүний нөөцийн хөгжил, ажиллах нөхцөл, ниймийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт..... 7-51 хуудас

ГУРАВДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

- ✓ Үйл ажиллагаа, төсөв санхүүгийн ил тод байдал
- ✓ Хүний нөөцийн ил тод байдал 51-52 хуудас

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

“ТАНИЛЦУУЛГА”

Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 68 дугаар тогтоолоор Нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Аялал жуулчлалын газар ажиллуулахаар тогтоож, Нийслэлийн Засаг даргын 2009 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 14 дүгээр захирамжаар 12 орон тоотой үүнээс дарга -1 байхаар баталж, Газрын даргын 2009 оны 01 дүгээр тушаалаар ахлах мэргэжилтэн-2, мэргэжилтэн-9 албан хаагчтай анх үйл ажиллагаагаа эхэлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2013 оны “Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг батлах тухай” А/323 дугаар захирамжаар газрын бүтэц, орон тоог нэмэгдүүлэн шинэчлэн 18 орон тоотой байхаар баталж, үүнээс дарга 1, ахлах мэргэжилтэн-2, мэргэжилтэн-12 /ТЗ/, мэдээллийн төвийн менежер-1, мэдээллийн технологи хариуцсан инженер-1, архив, бичиг хэргийн эрхлэгч-1 /ТҮ/ албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа өргөжүүлсэн.

Нийслэлийн Засаг даргын 2016 оны “Дүрэм батлах тухай” А/831 дүгээр захирамжаар тус газрын дүрэм, 2019 оны А/241 дүгээр захирамжаар бүтэц, орон тооны хязгаарыг баталж, газрын дарга-1, орлогч дарга-1, Захиргааны хэлтэс-6, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс-5, Мэдээлэл, сурталчилгааны хэлтэстэй-5 буюу үндсэн ажилтан 18, хөдөлмөрийн гэрээгээр мэдээлэл, сурталчилгааны төвийн ажилтан-3, нийт 21 албан хаагчтайгаар үйл ажиллагаагаа явуулав.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1059 дүгээр захирамжаар тус газрын бүтэц, орон тооны хязгаарыг 18 байхаар баталж, үүнээс дарга-1, Захиргаа, санхүүгийн хэлтэс, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс гэсэн 2 зохион байгуулалтын нэгжтэй байхаар баталсан.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар “Газрын дүрэм”-ийг шинэчлэн батлуулж үйл ажиллагаандаа мөрдөж, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэлийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөө, “Хотын иргэний жил”-ийн арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд нийслэл хотод аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа байгууллага аж ахуйн нэгж, иргэдийг мэргэжлийн удирдлага, дэмжлэгээр хангах, нийслэл хотыг гадаад, дотоодод сурталчлах, төрөөс аялал жуулчлалын чиглэлээр баримтлах бодлогыг хэрэгжүүлэх, холбогдох хууль тогтоомжийг мөрдүүлэхэд гол үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллаж байна.

✓ **АЛСЫН ХАРАА:**

Албан бизнесийн аялал жуулчлал болон нүүдэлчдийн түүх өв уламжлалыг хадгалсан соёлын үйлдвэрлэл, үйлчилгээ бүхий Монгол Улсын аялал жуулчлалын гол зангилаа байна.


✓ **ЭРХЭМ ЗОРИЛГО:**

Нийслэл Улаанбаатар хотыг үндэсний онцлог бүхий аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ өндөр хөгжсөн, олон улсад өрсөлдөх чадвартай хот болгон хөгжүүлэхэд оршино.

✓ **ҮНДСЭН ЧИГ ҮҮРЭГ:**

- ❖ аялал жуулчлалын болон жуулчны үйлчилгээний байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтарч ажиллах;
- ❖ аялал жуулчлалын байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;
- ❖ нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, Улаанбаатар хотыг гадаад улсад сурталчлах маркетингийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;
- ❖ нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаачидтай хамтран судалгаа хийж, хэлэлцүүлэг зохион байгуулах;
- ❖ нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтарч ажиллах;
- ❖ аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөг нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;
- ❖ аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;
- ❖ жуулчдыг татах болон аялал жуулчлалын салбарт соёлын нөлөөллийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;
- ❖ гадаад оронд зохион байгуулагдах аялал жуулчлалын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, арга хэмжээнд аялал жуулчлалын болон жуулчны үйлчилгээний байгууллагуудыг хамруулах;
- ❖ нийслэлийн аялал жуулчлалын нөөцөд түшиглэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, шинээр бий болгох ажлыг зохион байгуулах;
- ❖ гадаад, дотоодын жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах, мэдээллийн товхимлуудыг тогтмол шинэчлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;
- ❖ нийслэлийн хэмжээнд аялал жуулчлалын салбарын мэдээллийн санг хөтлөх;
- ❖ “жуулчны мэдээллийн төв”-үүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх;
- ❖ жуулчдын санал, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх;
- ❖ гадаад, дотоодын жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчинд зорчих, аялах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах.

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН БҮТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ



**НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН
2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

2022 оны 12 дугаар сарын 08

Улаанбаатар хот

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ,
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН**

Нэг.Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, үр дүн

1.1.1.“Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийн 1 зорилтын 5 арга хэмжээний хэрэгжилт 96.0 хувь, “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 1 зорилтын 1 арга хэмжээний хэрэгжилт 90.0 хувь, “Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 2 зорилт 3 арга хэмжээний хэрэгжилт 96.6 хувь, “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний 4 зорилтын 4 арга хэмжээний хэрэгжилт 96.6 хувь биелсэн.

Хүснэгтээр үзүүлбэл:

№	Бодлогын баримт бичгийн нэр	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
1.	“Алсын хараа-2050”	1	5	96.0%
2.	“Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”	1	1	90.0%
3	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	2	3	96.6%
4.	Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөө	4	4	96.6%
Нийт дундаж		8	13	94,8%

1.1.2.“Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 1 зорилтын 3 арга хэмжээ 96.0 хувь, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 5 зорилт 7 арга хэмжээний хэрэгжилт 97.0 хувь, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний 5 зорилт 10 арга хэмжээний хэрэгжилт 98.0 хувь, “Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө”-ний 1 зорилт 11 арга хэмжээний хэрэгжилт 98.0 хувьтай биелсэн.

Хүснэгтээр үзүүлбэл:

№	Бодлогын баримт бичгийн нэр	Зорилтын тоо	Арга хэмжээний тоо	Хэрэгжилтийн хувь
1.	Нийслэлийн 2020-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл	1	3	96.0%
2.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	5	10	97.0%
3.	Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө	5	11	98.0%
4.	Нийслэлийн 2022 оны хөгжлийн төлөвлөгөө	1	19	98.0%
Нийт дундаж		12	43	97,2%

1.1.3. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн байгаль орчин, аялал жуулчлалын салбарт 2022 онд хамтран ажиллах гэрээнд туссан арга хэмжээний 1 зорилтын 15 арга хэмжээний биелэлт 99.0 хувийн хэрэгжилттэй биелсэн.

Хүснэгтээр үзүүлбэл:

“Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай байгуулсан хамтран ажиллах гэрээний арга хэмжээний хэрэгжилтийн дүн		
Нийт арга хэмжээний тоо		15
1. Бүрэн хэрэгжсэн	100 хувь	14
2. Үр дүн гарсан	90 хувь	-
3. Тодорхой хэмжээнд үр дүн гарсан	70 хувь	1
4. Ажил эхэлсэн	50 хувь	-
5. Боловсруулалтын шатанд	30 хувь	-
6. Бэлтгэл ажлыг хангаж байгаа /ажил зохион байгуулаагүй	0 хувь	-
7. Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	-	-
Хэрэгжилтийн хувь		99.0%

Хоёр.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, үр дүн

✓ **Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт:**

1.2.1. Байгууллагын хяналтад 9 хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 14 заалтыг бүртгэж, Ерөнхийлөгчийн 1 зарлигийн 2 заалт 100%, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 1 тэмдэглэл 1 заалтын хэрэгжилт 90%, Засгийн газрын 4 тогтоолын 7 заалтын хэрэгжилт 100%, Засгийн газрын хуралдааны 4 тэмдэглэлийн 4 заалтын хэрэгжилт 92.5% гүйцэтгэлтэй хэрэгжиж, нийт хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 95.6% биелэлттэй хэрэгжсэн.

Төрлөөр нь авч үзвэл:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн төрөл	Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	Бүрэн хэрэгжсэн /90-100/	Хэрэгжих шатандаа /50-89/	Хэрэгжилт хангалтгүй /10-49/	Хэрэгжээгүй /0-9/	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Биелэлтийн дундаж
Ерөнхийлөгчийн зарлиг	1	2	2					100%
Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэмдэглэл	1	1	1					90%
Засгийн газрын тогтоол	3	7	7					100%
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	4	4	3	1				92.5%
НИЙТ	9	14	13	1				95,6%

Байгууллагын хяналтад бүртгэсэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, биелэлтийг хангах 2 бүлгийн 21 заалт бүхий ажлын төлөвлөгөө баталж хэрэгжилт 95.7 хувь биелсэн бөгөөд тайланг нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлж хугацаанд нь тайлагнасан.

✓ **Захирамжлалын баримт бичгийн биелэлт:**

1.2.2. Байгууллагын хэмжээнд тайлант хугацаанд 42 захирамжлалын баримт бичгийн нийт 54 заалт буюу нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 1 тогтоол шийдвэрийн 1 заалт үүрэг даалгаврын хэрэгжилт 90.0%, нийслэлийн Засаг даргын 26

захирамжийн 28 заалт үүрэг даалгаврын хэрэгжилт 94.6%, нийслэлийн Засаг даргын зөвлөлийн Хурлын 15 тэмдэглэлийн 25 заалт үүрэг даалгаврын хэрэгжилт 99.8%-ийн биелэлттэй үнэлэгдсэн.

Төрлөөр нь авч үзвэл:

Захирамжлалын баримт бичгийн төрөл	Хяналтад авсан нийт шийдвэрийн тоо	Хяналтад авсан нийт зүйл, заалтын тоо	Бүрэн хэрэгжсэн /90-100/	Хэрэгжих шатандаа /50-89/	Хэрэгжилт хангалтгүй /10-49/	Хэрэгжээгүй /0-9/	Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	Биелэлтийн дундаж
Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол	1	1	1					90.0%
Нийслэлийн Засаг даргын захирамж	26	28	25	3				94.6%
Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хурлын тэмдэглэл	15	25	25					99.8%
НИЙТ	42	54	51	3				94.8%

✓ **“Хотын иргэний жил”-ийн төлөвлөгөөний хэрэгжилт:**

1.2.3.Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/01 дүгээр захирамжаар 2022 оныг “Хотын иргэний жил” болгон зарласантай холбогдуулан нийслэлийн нэгдсэн төлөвлөгөөтэй уялдуулан тус газраас хэрэгжүүлэх дүрэм, стандартыг сурталчлах, хотын соёлыг төлөвшүүлэх, хөдөлмөр эрхлэлт, орлого нэмэгдүүлэх, амьдрах орчныг сайжруулах чиглэлээр 4 зорилтын 15 арга хэмжээний төлөвлөгөөг баталж, “Хотын иргэний жил”-ийн төлөвлөгөөний биелэлт 2022 оны хагас жилийн байдлаар 73.3 хувийн гүйцэтгэлтэй, жилийн эцсийн байдлаар 100 хувийн гүйцэтгэлтэй биелэсэн.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН:

Нэг.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан

2.1.1.Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 217 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам"-ын хүрээнд байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын 58 арга хэмжээг хэрэгжүүлэхээр боловсруулан батлуулж, гүйцэтгэлийн тайлан эхний хагас жилийн байдлаар 80.8 хувийн гүйцэтгэлтэй, жилийн эцсийн байдлаар 96.5 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж хугацаанд нь тайлагнасан.

Хүснэгтээр үзүүлбэл:

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 2022 оны гүйцэтгэлийн тайлан		
Нийт арга хэмжээний тоо		58
1. Бүрэн хэрэгжсэн	90-100 хувь	54
2. Хэрэгжих шатанд	70 хувь	1
3. Хэрэгжилт хангалтгүй	50 хувь	3
4. Хэрэгжээгүй	0 хувь	-
5. Хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй	-	
Үнэлгээний дундаж хувь		96.5%

Хоёр.Газрын дүрмээр хүлээсэн үүргийн хэрэгжилт:

2.2.Аялал жуулчлалын болон жуулчны үйлчилгээний байгууллагуудыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хамтарч ажиллах;

2.2.1.Монгол Улсын Засгийн газрын ээлжит бус хуралдаанаар гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг цуцалж, шар түвшинд шилжүүлсэнтэй холбогдуулан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас санаачлан 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдсан “Шинэ сэргэлтийн бодлого-Аялал жуулчлал” хэлэлцүүлэг, “Монголын эдийн засгийн чуулган 2022- Шинэ сэргэлт”, “Аж үйлдвэржилтийн сэргэлт” урьдчилсан хэлэлцүүлгийн хүрээнд 03 дугаар сарын 24-ний өдөр зохион байгуулагдсан “Шинэ сэргэлтийн бодлого-Аялал жуулчлал” хэлэлцүүлэгт давхардсан тоогоор салбарын нийт 250 гаруй аж ахуйн нэгж, байгууллагуудын төлөөллийг оролцуулж, холбогдох шийдвэрүүдийг гаргуулж хамтран ажилласан.





2.2.2.Монгол Улсын Засгийн газраас 2023, 2024 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Засгийн газрын 2022 оны 371 дүгээр тогтоолоор Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хороо шинэчлэн баталсан. Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хороонд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий Аялал жуулчлалын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг боловсруулах, батлуулах дэд ажлын хэсэг, Нэгдсэн цахим платформуур дамжуулан Монгол Улсыг олон улсад сурталчлах, аялал жуулчлалын цахим шилжилтийг нэвтрүүлэх дэд ажлын хэсэг, Аялал жуулчлалын салбарт мөрдөгдөж буй үйлчилгээний стандартуудыг шинэчлэх, олон улсын жишигт нийцүүлэн шинээр стандартуудыг боловсруулан батлуулах дэд ажлын хэсэг, Монгол Улсыг гадаадад сурталчлах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний арга хэмжээний нэгдсэн календарийг боловсруулах батлуулах олон улсад зарлах ажлыг зохион байгуулах дэд ажлын хэсгүүдэд Монголын Аялал жуулчлалын холбоо, Монголын Зочид буудлуудын холбоо, Монголын Жуулчны баазуудын холбоо, Аялал жуулчлалын боловсрол, хөгжлийн нийгэмлэг зэрэг салбарын мэргэжлийн байгууллагуудын 80 төлөөллүүдийг оролцуулан хамтран ажиллаж, холбогдох шийдвэрүүдийг гаргуулан ажиллаж байна.



2.2.3. Нийслэлийн Засаг даргын 2021 оны “Бизнес эрхлэх таатай орчныг бүрдүүлж, авлига, хүнд суртлыг бууруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/987 дугаар захирамжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд үйлчилгээний байгууллагуудыг системд хамруулах, бүртгүүлэх зорилгоор байгууллагын www.ub.gov.tourism.mn цахим хуудас, газрын facebook хуудсанд мөрдөгдөж буй стандарт, тавигдах шаардлагыг ханган татварын албанд бүртгүүлснээр нийслэлийн нутаг дэвсгэрт байр сууцны үйл ажиллагаа эрхлэх талаар холбогдох мэдээллийг аж ахуйн нэгж, байгууллагуудад өгч, арга зүйн удирдлагаар ханган ажилласан.

“Онлайн бизнес” төвийн Үйлчилгээ эрхлэх бүртгэлийн нэгдсэн системд тайлант хугацаанд 430 (өссөн дүнгээр) аж ахуйн нэгж, байгууллага зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын чиглэлээр үйл ажиллагаа эрхлэхээр хүсэлт гаргаж, үүнээс шийдвэрлэсэн-145, шилжүүлсэн-262, судалж байгаа-0, илгээсэн-0, татгалзсан-2, буцаасан-21 гэсэн явцтай байгаа бөгөөд холбогдох хүсэлтийг тухай бүр шийдвэрлэсэн.



2.2.4. Монголын Аялал жуулчлалын холбоо, “Зочлох үйлчилгээний салбарын сургалт хөгжлийн төв”, “Монголын гастроном аялал жуулчлалын холбоо” ТББ-тай хамтран аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг жуулчны үйлчилгээний байгууллагууд, тур операторуудын туршлага солилцох “Аялал жуулчлал – Бизнес хэлцэл”-2022 арга хэмжээг 4 дүгээр сарын 13, 14-ний өдрүүдэд “Баянгол зочид” буудалд зохион байгууллаа. Арга хэмжээнд жуулчны үйлчилгээний 80 гаруй байгууллага, 200 орчим тур оператор компанийн төлөөллүүд оролцож, жуулчны үйлчилгээний байгууллага, тур операторуудад нэг дор гэрээ хийж хамтран ажиллах боломжийг бүрдүүлсэн.



2.3. Аялал жуулчлалын байгууллагуудын үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, жуулчин хүлээн авах хүчин чадлыг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

2.3.1. Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны 2022 оны 03 дугаар тогтоолоор байгуулагдсан “Аялал жуулчлалын салбарт мөрдөгдөж буй үйлчилгээний стандартуудыг шинэчлэх, олон улсын жишигт нийцүүлэн шинээр стандартуудыг боловсруулан батлуулах ажлыг зохион байгуулах дэд ажлын хэсэг”-г Монгол улсын шадар сайдаар ахлуулан байгуулсан. -Дээрх дэд ажлын хэсэгт орж ажиллаж “Зочид буудлын ерөнхий шаардлага MNS 4588:2008”, “Аялал жуулчлал. Дэн буудлын ерөнхий шаардлага MNS 5738:2007”, “Амралтын газар, жуулчны баазын ерөнхий шаардлага MNS 4963:2019” стандартуудыг шинэчлэх ажлыг зохион байгуулж байна.

2.3.2. Байгал орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны А/86 дугаар тушаалаар байгуулагдсан “Зэрэглэл тогтоох ажлын хэсэг”-ийн бүрэлдэхүүнд ажиллаж 11 байгууллагад стандартыг сурталчилж, 7 байгууллагад “Зочид буудлын үйлчилгээний чанарын зэрэглэл, үндсэн шаардлага MNS 5927:2008” стандартын үнэлгээ хийх ажлыг зохион байгуулсан.

✓ “HOSPITALITY-2022” нэгдсэн арга хэмжээ

2.3.3. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын Зочид буудлуудын холбоотой хамтран “HOSPITALITY-2022” нэгдсэн арга хэмжээг “Зочид буудал, зоогийн газрын хангамжийн үзэсгэлэн, зочлох үйлчилгээний салбарын мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээн, “Аялал жуулчлал ба ажил эрхлэлт”, “Зочлох үйлчилгээний салбарын цахим шилжилт, шийдэл” хэлэлцүүлэг” гэсэн 4 чиглэлээр 2022 оны 05 дугаар сарын 13,14-ний өдрүүдэд Улаанбаатар зочид буудлын үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулав.

“Зочид буудал, зоогийн газрын хангамжийн үзэсгэлэн”-д орон нутгийн Аялал жуулчлалын газрууд, салбарын мэргэжлийн холбоод, зочлох үйлчилгээний чиглэлээр боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургууль зэрэг 45 байгууллага, зочлох үйлчилгээний салбарын мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээнд зочид буудлуудын 41 ажилтан, “Зочлох үйлчилгээний салбарын цахим шилжилт, шийдэл” хэлэлцүүлэг”-т зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 60 гаруй иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөл оролцсон бөгөөд арга хэмжээг 5000 гаруй иргэн үзэж сонирхсон.



✓ “Зочлох үйлчилгээний салбарын цахим шилжилт, шийдэл” хэлэлцүүлэг

Зочлох үйлчилгээний салбарт дэвшилтэд технологи нэвтрүүлэх, үйлчилгээг түргэн шуурхай үзүүлэх, цахим хэлбэрт шилжүүлэх зорилгоор зохион байгуулагдсан “Зочлох үйлчилгээний салбарын цахим шилжилт, шийдэл” хэлэлцүүлэгт зочид буудлын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 60 гаруй иргэн, аж ахуйн нэгж байгууллагын төлөөлөл оролцож санал бодлоо хуваалцсан.



✓ “Аялал жуулчлал ба ажил эрхлэлт”

Аялал жуулчлалын салбарт ажиллах сонирхолтой оюутан залуус, иргэдийг эзэмшсэн мэргэжлийнхээ дагуу түр болон байнгын ажлын байртай болгох, аялал жуулчлалын байгууллагуудад шаардлагатай ажилтнаа олоход нь дэмжлэг үзүүлэх, ажил олгогч, ажил хайгч иргэдийг холбох зорилгоор “Аялал жуулчлал ба ажил эрхлэлт” хөдөлмөрийн яармагт жуулчны бааз, тур оператор компани, зочид буудал, зоогийн газар зэрэг аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудаас ирүүлсэн 252 нээлттэй ажлын байрны мэдээллийг 2 үзэсгэлэн, арга хэмжээний үеэр 800 гаруй иргэнд сурталчлан, ажлын байранд шууд зуучлах, нээлттэй ажлын байр зарласан жуулчны бааз, тур оператор, зоогийн газар, зочид буудлын ажил олгогчид ажилд бүртгэх ажлыг хамтран зохион байгуулсан.



Нийслэлийн Аялал
жуулчлалын газар

Visit *Ulaanbaatar*
CITY OF WONDERS



- ЖУУЛНЫ БААЗ
- АМРАЛТЫН ГАЗАР
- ЗОЧИД БУУДАЛ
- ЗООГИЙН ГАЗАР
- ТУР ОПЕРАТОР
- РАШААН СУВИЛАЛ
- МУЗЕЙ

70128687




2.4. Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх, Улаанбаатар хотыг гадаад улсад сурталчлах маркетингийн төлөвлөгөө боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

2.4.1. Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны 2022 оны 03 дугаар тогтоолоор байгуулагдсан “Нэгдсэн цахим платформоор дамжуулан Монгол Улсыг олон улсад сурталчлах, аялал жуулчлалын цахим шилжилтийг нэвтрүүлэх дэд ажлын хэсэг,”-г Цахим


хөгжил, харилцаа холбооны сайдаар, Монгол Улсыг гадаадад сурталчлах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээний арга хэмжээний нэгдсэн календарийг боловсруулах батлуулах олон улсад зарлах ажлыг зохион байгуулах дэд ажлын хэсэг"-ийг Гадаад харилцааны сайдаар ахлуулан байгуулсан бөгөөд дээрх ажлын хэсгүүдэд орж ажиллаж Улаанбаатар хотыг сурталчлах арга хэмжээ болон нийслэлд зохион байгуулдаг жуулчдад зориулсан эвент арга хэмжээний талаарх мэдээллийг танилцуулан нэгдсэн төлөвлөгөөнд тусгуулах бөгөөд байгууллагын маркетингийн төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллав.

2.4.2. Жуулчдын тоог нэмэгдүүлэх, татах зорилгоор эвент арга хэмжээ болон Улаанбаатар хотын сурталчилгааны 12 төрлийн сурталчилгааны контент хийгдсэн. Үүнд: “Улаанбаатар явган аялал”, “Унгарын соёлын өдрүүд”, “Хоспиталити” мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээн, “Хотын аяллын” влог, Сити тур хотын аяллаар “Том ахын аялал” нэвтрүүлэг 2, “Generation” нэвтрүүлэг, “Дээлтэй монгол наадам”, “Сүүн зам” олон улсын бүжгийн наадам, “Даншиг наадам хүрээ цам наадам”, “Улаанбаатар хоолны олон улсын хоолны өдөрлөг Арт гэр олон орны хоолны влог, “KBS” солонгосын телевизтэй хамтран Монгол улс Улаанбаатар хотыг сурталчлах нэвтрүүлэг зэргийг бий болгон олон нийтэд сурталчилсан. “Сити оф номадс” төслийн хүрээнд Улаанбаатар хотыг сурталчлах “Юу хийх вэ?”, Улаанбаатар хотын уугуул иргэдийн талаарх сонирхолтой мэдээлэл, сар бүрийн нийслэлд болж буй арга хэмжээ, үйл ажиллагаа зэргийг багтаасан мэдээлэл, 22 төрлийн цуврал контент хийж сурталчилсан.


БИДНИЙ ХӨРШҮҮД




2.4.3. Улаанбаатар хот болон аялал жуулчлалын гадаад сурталчилгааны мэдээ мэдээллийг багтаасан “Visitulaanbaatar” цахим сэтгүүлийг Англи Монгол хэлээр гаргаж, QR code үүсгэн, сурталчилгааны материал болгон гадаад хэргийн ямаар дамжуулан ЭСЯ, Консулын газруудаар дамжуулан ажилласан.



2.4.4. Улаанбаатар хотыг гадаад улс оронд сурталчлах www.Visitulaanbaatar.net цахим хуудсанд хөгжүүлэлт хийж жуулчдад хэрэгцээт цаг үеийн шинж чанартай мэдээ, мэдээллийг тогтмол /англи хэл дээр бэлтгэн/ оруулж нийт 25,406 хүнд сурталчилсан. Цахим сайтын мэдээг эх сурвалжаас 54.1%, facebook хуудаснаас 15.8%, Google-ээс 30.1% үзэж, Улаанбаатар хотын өнгө төрхийг харуулах 360 градусын 4 багц 25 ширхэг зургийн санг үүсгэн байршуулж, нийслэлийн мэдээ мэдээллийн www.Ulaanbaatar.mn цахим хуудастай холбож үйл ажиллагааг олон нийтэд сурталчилсан. Байгууллагын: www.tourism.ub.gov.mn цахим хуудсанд 20,000, www.visitulaanbaatar.net цахим хуудсанд 25,406, facebook хуудсанд 747,000 гаруй хандалттай байна.




2.4.5. Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааг эрчимжүүлэх ажлын хүрээнд “Кью Эн Эс” ХХК-ийн Хөсөг төсөлтэй хамтран Улаанбаатар брэнд лого, өнгө дизайн, уриа үг бий болгох ажлыг гүйцэтгэсэн. Хөсөг” брэндийн эсгий урлал, “Тэрэн” брэндийн тоглоом, бэлэг дурсгалын бүтээгдэхүүн, “Мери марта” жуулчдад зориулсан гар урлалын бүтээгдэхүүн, сав баглаа боодол зэрэг 10 төрлийн бүтээгдэхүүнд, brandbook 31 төрлийн бүтээгдэхүүн “Visit Ulaanbaatar” логог байршуулав.





2.5. Нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр их, дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага, эрдэмтэн, судлаачидтай хамтран судалгаа хийж, хэлэлцүүлэг зохион байгуулах;

2.5.1. Улаанбаатар аялал жуулчлалын холбоо, Монгол Үндэсний Их сургуулийн судлаачидтай хамтран Монгол Улсын Аялал жуулчлалын салбарын алдагдал 2021 он судалгааны ажилд хамтран оролцсон. Мөн “Аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчдэд үзүүлж буй цар тахлын нөлөө” судалгааг Монголын Үндэсний Худалаа Аж Үйлдвэрийн танхимын Аялал жуулчлалын зөвлөлийн санаачилгаар Эдийн засгийн судалгааны институтээс холбогдох байгууллагуудтай хамтран түүвэр судалгааны ажлыг хийж гүйцэтгэсэн. Уг судалгаагаар Аялал жуулчлалын салбар нь цар тахлын нөлөөнд хамгийн их өртөж 2021 онд ирсэн жуулчдын тоо 33.1 мянга болж 2019 онтой харьцуулахад 94.3%-иар буурсан, салбарын орлогын хувьд 2020-2021 онд 3 их наяд гаруй төгрөгийн алдагдал хүлээжээ. Судалгаанд оролцсон нийт байгууллагуудын орлого дундажаар 76.0% буурсан бол ажлын байр 63%-иар хорогдсон тооцоо судалгаа гарсан.



2.5.2. Аялал жуулчлалын салбарт нөлөөлж буй бизнесийн орчны тодорхойгүй нөхцөл байдлууд оролцогч талуудын уялдаа холбоо хамтын стратегид хэрхэн нөлөөлж буйг тодорхойлон өнөөгийн хамтын стратегийн түвшнийг хэмжих, цаашид хөгжүүлэх боломжит хувилбарыг санал болгох зорилгоор Санхүү эдийн засгийн сургуультай хамтран Аялал жуулчлалын салбарт нөлөөлж буй бизнесийн орчны тодорхойгүй нөхцөл байдлууд оролцогч талуудын уялдаа холбоо, хамтын стратегид хэрхэн нөлөөлж буйг тодорхойлон өнөөгийн хамтын стратегийн түвшнийг хэмжих, цаашид хөгжүүлэх боломжит хувилбарыг санал болгох зорилгоор 5 хэсэг бүхий нийт 66 асуулттай судалгааг Улаанбаатар хот болон 21 аймагт үйл ажиллагаа эрхэлж буй амралтын газар, жуулчны баазуудын захирал болон менежерүүдээс судалгааг авч нэгтгэсэн.

2.6. нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр гадаад, дотоодын байгууллагуудтай хамтарч ажиллах;

2.6.1. Дэлхийн аялал жуулчлалын салбарын хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулах, хот хоорондын хамтын ажиллагааг эрчимжүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээ болон туршлагыг түгээх зорилготой байгуулагдсан Дэлхийн Аялал жуулчлалын хотуудын холбоонд элсэх хүсэлт, байгууллагын танилцуулгыг Ази, номхон далайн бүс нутаг хариуцсан албан тушаалтанд хүргүүлж, Дэлхийн Аялал жуулчлалын хотуудын холбооны удирдах зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн хурлаар шийдвэрлэж, элсүүлсэн батламжаа хүлээн авсан.

2.6.2. Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран “TOURISM TIME-2” уулзалт, арга хэмжээг 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулж, арга хэмжээнд Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, төр, хувийн хэвшлийн түншлэлийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Ж.Сандагсүрэн болон аялал жуулчлалын бизнес эрхлэгч компанийн төлөөлөл оролцож тус газраас “Нийслэлд болох эвент арга хэмжээний танилцуулга” мэдээлэл хийсэн бөгөөд нийслэлийн Аялал жуулчлалын газар Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран ажиллах ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2.6.3. Монгол Улсын Засгийн газраас “Шинэ сэргэлтийн бодлого”-ын хүрээнд “Аялал жуулчлалын үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын бүс нутгийн хөгжлийг хангах, орон нутгийн түүх, соёл, угсаатны өвд тулгуурласан соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлэх” дэвшүүлсэн зорилтын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 04 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулагдсан 21 аймгийн аялал жуулчлалын асуудал хариуцсан байгууллагын удирдлагууд, мэргэжилтнүүд, мэргэжлийн холбоодод зориулсан “Аялал жуулчлалын холбоодын үндэсний чуулган”, “Орон нутгийн аялал жуулчлалын хөгжлийн асуудал” сургалт, уулзалтад оролцож Улаанбаатар хотод зохион байгуулагдах эвент арга хэмжээний талаар танилцуулсан.




2.6.4. Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд Нийслэлийн иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх, байгалийн сайханд эрүүл орчинд амрах, зугаалах нөхцөлийг бий болгох, гадаад, дотоодын аялагч, амрагчдад мод тарих боломжийг бүрдүүлэх зорилгоор “Сая жуулчин-Сая мод” аяны хүрээнд “Нэг жуулчин-Нэг мод” жуулчин төглийг Монголын Аялал жуулчлалын холбоо, аялал жуулчлалын 24 байгууллагатай хамтран Налайх дүүргийн “Шинэ Налайх” цэцэрлэгт хүрээлэнд бий болгож, мод тарих нээлтийн өдөрлөгийг 2022 оны 05 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулж, жуулчин төгөлд гацуур, шинэс, агч, нарс, хус, гүйлс, монос, нохойн хошуу, тэхийн шээг, паркийн сарнай зэрэг нийт 14 төрлийн 380 гаруй мод, бут тарьж суулгах ажлыг зохион байгууллаа.



2.6.5. Аялал жуулчлал, зочлох үйлчилгээний салбарын бизнес эрхлэгчдийн “Хамтын ажиллагаа” сэдэвт хэлэлцүүлэг 2022 оны 10 дугаар сарын 26-ны өдөр зохион байгуулагдаж, “Төрөөс 2023-2024 оныг Монголд зочлох жил болгон зарласантай холбоотой аялал жуулчлалыг хөгжүүлэхэд баримтлах бодлого чиглэл”, “Зочлох жилд бид юуг хийх вэ?”, “Жуулчны баазуудын үйлчилгээнд гарч буй өөрчлөлт, сайжруулах хүчин зүйлс”, “Тур оператор компаниудын үйлчилгээ хамтын ажиллагаа”, “Зочид буудлын үйлчилгээнд гарч буй өөрчлөлт, анхаарах хүчин зүйлс” сэдвийн хүрээнд аялал жуулчлалын гол үйл ажиллагаа эрхлэгч тур оператор, байршуулах үйлчилгээ эрхлэгч жуулчны бааз, зочид буудлын бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагаа, гэрээ хэлцэл хийх хугацаа, нөхцөл, үйлчилгээний үнийн асуудал зэрэг асуудлыг хэлэлцүүлж, салбарын 100 гаруй төлөөлөл хувийн хэвшил, мэргэжлийн холбоод, түншлэгч нар оролцлоо.



2.6.6. Нийслэлийн Дагуул хот, эдийн засгийн тусгай бүсийн хөгжлийн газраас зохион байгуулсан дагуул хот, эдийн засгийн тусгай бүс байгуулах газрын байршилтай танилцах аяллын хүрээнд Нийслэлийн Аялал жуулчлалын газрын удирдлага, холбогдох мэргэжилтэн Улаанбаатар хот орчмын эдийн засгийн болон бүс нутгийг хөгжүүлэх боломжтой таван байршилтай танилцсан.



2.6.7. Хотын соёлыг төлөвшүүлэх, иргэдийн чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх орчин, нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор цагийн хязгаартай ажиллах авто машингүй гудамж, талбайн судалгааг гаргах, төсөл хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд Соёлын яам, нийслэлийн “Жижиг дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв” НӨҮГ, “Улаанбаатар хөрөнгө оруулалт менежмент ҮЦК” ХХК-ийн удирдлага холбогдох албан тушаалтнуудтай уулзалт хийж автомашингүй гудамжны төслийн талаар хамтран ажилласан.

2.6.8. Улаанбаатар хотод эко аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүн, ажлын байрыг нэмэгдүүлэх, аялал жуулчлалын цогцолбор бий болгох зорилгоор Сонгинохайрхан дүүргийн 32 дугаар хороонд байрлах “Шувуут нуур”-ыг аялал жуулчлалын мега гудамж болгохыг дэмжиж байгаа бөгөөд тохижилтын ажлын зураг төсөлд тусгах саналыг Олон улсын худалдаа логистикийн төв ХК-д албан бичгээр хүргүүлсэн.

2.7. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх төлөвлөгөөг нийслэлийн хөгжлийн бодлогод нийцүүлэн боловсруулж, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах;

2.7.1. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэх, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 2 зорилт 9 арга хэмжээний төлөвлөгөө гарган баталж, хэрэгжилтийг 100 хувь ханган ажиллаа.

✓ **“Guide 100–Уран илтгэгч” тэмцээн**

2.7.2. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, бүрдүүлэх, мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажил мэргэжлийг сурталчлах зорилгоор Монголын Аялал жуулчлалын салбарт хувийн хэвшил үүсч байгуулагдсаны 30 жилийн ой, Guide боловсролын төвийн 100 дахь сургалтад зориулж элсэгч, төгсөгчдийн дунд гадаад хэлээр зохион байгуулж буй 3 дахь шат буюу шилдгийг шалгаруулах “Guide 100–Уран илтгэгч” тэмцээнийг 2022 оны 11-р сарын 26-ны өдөр Нийслэлийн Хангарьд ордны хурлын Их танхимд зохион байгуулж, тэмцээнд шилдэг 12 оролцогч англи, герман, солонгос, турк хэлээр Монголын түүх, өв соёл, ёс зан заншил, зан үйлийн гарал, утга, ач холбогдолын талаар өгөгдсөн сэдвийн хүрээнд илтгэл тавьж, шүүгчдийн асуултад хариулж, шилдэг уран илтгэгчийг шалгарууллаа.



✓ **“Зочлох үйлчилгээний салбарын мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээн”**

2.7.3.Салбарын хүний нөөцийг чадваржуулах, туршлага солилцох, ажил мэргэжлийг сурталчлах зорилгоор “Зочлох үйлчилгээний салбарын мэргэжлийн аварга шалгаруулах тэмцээн”-ийг 2 үе шаттай зохион байгуулж, тэмцээнд “Бишрэлт”, “Сан”, “Холидэй инн”, “Ибис”, “Ханбүргэд” зочид буудал /Хэнтий аймаг/, “Жаргалант” амралт, сувилал зэрэг байгууллагын 41 ажилтан “Зочин хүлээн авагч”, “Өрөө үйлчилгээ”, “Зөөгч”, “Бар-тендер” гэсэн ажил мэргэжлээр шилдгүүдээ тодруулж, ажил мэргэжлээ тэргүүлсэн оролцогчдод 1 сая төгрөгийн шагнал, урамшуулал олгосон.



✓ **“Grand tour” аялал жуулчлалын Улсын олимпиад**

2.7.4.Дэлхийн аялал жуулчлалын өдрийг угтан “GRAND TOUR” аялал жуулчлалын Улсын олимпиадыг 20 дахь жилдээ хамтран 2022 оны 9 дүгээр сарын 18-27-ны өдрүүдэд зохион байгууллаа. Олимпиадыг “Cesim service” бизнесийн загварчлалын цахим тэмцээн, “Центавр” Танин мэдэхүйн тэмцээн, “Grand Tour” спорт явган аяллын тэмцээн, “Rethinking tourism-Монголын аялал жуулчлал” Оюутны эрдэм шинжилгээний бага хурал, “Rethinking tourism-Монголын аялал жуулчлал” Аялал жуулчлалыг сурталчлах үзэсгэлэн гэсэн үндсэн таван төрлөөр зохион байгуулж, аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 11 сургуулийн 15 багийн 300 гаруй оюутан залуучууд оролцсон.



2.8 Аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлага, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах;



2.8.1. Швейцарын хөгжлийн агентлаг (SDC), "Ай Хотел" ХХК-тай хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд аялал жуулчлалын салбарын нэгдсэн мэдээллийн сан, цахим экосистемийн хөгжлийг дэмжих замаар цахим сургалтын платформ бий болгох, салбар дахь бизнес эрхлэгчдийн цахим хэрэглээний чадавх мэдлэгийг дээшлүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх зорилгоор "My Hotel-Аялал жуулчлал, байрших үйлчилгээний салбар дахь цахим шилжилт төсөл" онлайн сургалтыг дүүргүүдийн Засаг даргын Тамгын газартай хамтран зохион байгуулж, 120 хүнийг сургалтад хамруулав.



2.8.2. Бүгд Найрамдах Солонгос Улсын Соёл, аялал жуулчлалын яамны санхүүжилтээр Аялал жуулчлалын ур чадварын мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран "Жуулчны баазын үйлчилгээний чанар, аюулгүй байдлыг сайжруулах нь" сэдэвт сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 06-10-ны өдрүүдэд зохион байгуулж 41 жуулчны баазын удирдлагыг хамрууллаа.



2.8.3. Салбарын хүний нөөцийн мэдлэг ур чадварыг дээшлүүлэх зорилгоор Зочин хүлээн авагч, Өрөө үйлчилгээ, Зөөгч ажилтнуудад зориулсан цахим гарын авлага видео хичээл бэлтгэн дүүргүүдийн Засаг даргын Тамгын газар, мэргэжлийн 11 холбоогоор дамжуулан Зочлох үйлчилгээний салбарын байгууллагууд хүргүүлж ажилласан.



2.8.4. Гадаад, дотоодын жуулчдад хэрэгцээт мэдээ, мэдээллийг хүргэх, эрх зүйн туслалцаа үзүүлэх зорилготой “Оюутан цагдаа-2022” арга хэмжээг Нийслэлийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах салбар зөвлөлийн дэмжлэгтэйгээр нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Монголын Оюутны холбоотой хамтран зохион байгуулж, арга хэмжээнд ажиллах 150 оюутанд хууль эрх зүй, жуулчны аюулгүй байдал, Улаанбаатар хотын түүх, соёлын дурсгалын тайлбар, хөтөч тайлбарлагчийн ур чадвар сэдвээр сургалт 2022 оны 06 дугаар сарын 16-ны өдөр зохион байгуулав.



2.8.5. Хотын стандартын талаар олон нийтийг мэдлэг, арга зүйгээр хангах, стандарт сурталчлах, мөрдүүлэх, зочлох үйлчилгээний салбарын чиг хандлага, үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Баянгол, Налайх, Сонгинохайрхан дүүргүүдийн Хүнс, худалдаа үйлчилгээний хэлтэс, Хотын стандарт, хяналтын газартай хамтран 2022 оны 09 дүгээр сарын 07, 12-ны өдрүүдэд аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагуудад “Хотын стандартыг мөрдүүлэх, сурталчлах, зочлох үйлчилгээний салбарын чиг хандлага, үйлчилгээний чанар, үйл ажиллагааг сайжруулах” сэдвээр сургалт зохион байгуулж, зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын 190 гаруй удирдлагууд хамрагдлаа.



2.8.6. “Чингис хааны музейг хэрхэн яаж тайлбарлах” сэдэвт сургалтыг Чингис хааны музейтэй хамтран 2022 оны 12 дугаар сарын 06-ны өдөр зохион байгуулж аялал жуулчлалын хөтөч тайлбарлагч, хөтөчөөр ажиллах сонирхолтой 50 хүн хамрагдлаа.

2.8.7. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, бүрдүүлэх, мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажил мэргэжлийг сурталчлах зорилгоор “Аяллын хөтөч-тайлбарлагч” бэлтгэх сургалтыг Гайд боловсролын төвтэй хамтран 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн 45 хоногийн хугацаатай зохион байгуулав. Сургалтаар Монголын түүх, газарзүй, өв соёл, зан заншил, зан үйлийг тайлбарлах, аяллын бүс, маршрут, аяллын хөтөч-тайлбарлагчийн техник, ур чадварыг эзэмшүүлэх, гадаад хэл дээр тайлбар хийх дадлага олгов. Сургалтад аялал жуулчлалын хөтөч тайлбарлагч, хөтөчөөр ажиллах 34 хүн хамрагдлаа.



Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг хөгжүүлэх, бүрдүүлэх, мэргэжлийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, ажил мэргэжлийн 11 удаагийн сургалтад 725 хүнийг хамруулж зохион байгуулсан.

2.9. Жуулчдыг татах болон аялал жуулчлалын салбарт соёлын нөлөөллийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулах;

2.9.1. Нийслэлийн Аялал жуулчлалын газар, нийслэлийн Соёл, урлагийн газар, нийслэлийн Биеийн тамир, спортын газар, Улаанбаатар театр хамтран нийслэл Улаанбаатар хотод 2022 онд аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр соёл, спорт, аялал жуулчлалын арга хэмжээг зохион байгуулах асуудлыг Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 06 дугаар хуралдаанаар хэлэлцүүлэн Улаанбаатар хотод 2022 онд олон улсын чанартай 34 соёл, спорт, аялал жуулчлалын арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж, чиг үүргийн арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан.



2.9.2. Улаанбаатар хотод 2022 онд зохион байгуулах аялал жуулчлалын 14 эвент арга хэмжээний видео танилцуулгыг газрын www.ub.gov.tourism.mn цахим хуудас болон салбарын цахим мэдээллийн сувгаар олон нийтэд таниулан сурталчилсан.



✓ **“Нүүдэлчдийн өв-Бүргэдийн баяр-2022”**

2.9.3. Казах түмний уламжлалт “Наурыз”-ын хаврын баярын хүрээнд Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Соёлын яам, Баян-Өлгий аймгийн нутгийн зөвлөл зэрэг байгууллагуудтай хамтран “Нүүдэлчдийн өв-Бүргэдийн баяр-2022” арга хэмжээг 2022 оны 03 дугаар сарын 12-ны өдөр Монгол Кувейтын байгаль төвд зохион байгууллаа.


Бүргэдийн баяраар бүргэдчид бүргэдээ хэрхэн сургасан байдлыг шалгаруулах үзүүлбэр, казахын ард түмний уламжлалт тоглоом тулам булаалдах тэмцээн, урлагийн тоглолт, шонхор шувууны үзүүлбэр, бүргэдээр ан бариулах шувуулахуйн үзүүлбэрүүдийг хүргэж, Казах үндэстний соёл уламжлалыг харуулсан дуу хөгжим, тоглоом наадгай, хувцас загварын үзүүлбэр, гар урлал болон бусад брэнд бүтээгдэхүүний үзэсгэлэн худалдаа зэрэг арга хэмжээ зохион байгуулдсан бөгөөд арга хэмжээг 5000 гаруй хүн үзэж сонирхов.



✓ **“Францын соёлын өдрүүд” арга хэмжээ**

2.9.4. “Францын соёлын өдрүүд” болон “Дэлхийн театрын өдрүүд”-ийг тохиолдуулан Улаанбаатар дахь Аллианс Франсез төв, Монгол Улс дахь Францын төлөөлөгчийн газартай хамтран “Франц хэлтэн орнуудын хотхон” үзэсгэлэн, соёл, аялал жуулчлалын өдөрлөгийг 2022 оны 03 дугаар сарын 27-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж, арга хэмжээнд сургалт судалгааны байгууллага, аялал жуулчлалын компани, ресторан, төрийн бус байгууллага, франц хэлтэн орнуудын дипломат төлөөлөгчийн газар зэрэг 40 гаруй байгууллага оролцож, франц хүнсний бүтээгдэхүүн амталгаа, шөлний тэмцээн, урлаг, соёлын арга хэмжээг зохион байгуулсан.


Арга хэмжээний үеэр Улсын Дуурь бүжгийн эрдмийн театрын тайзнаа тоглогдсон “Кармен” дуурийг нийслэл дэлгэцээр шууд дамжуулж олон нийтэд толилуулсан бөгөөд тус газраас “Жуулчны мэдээллийн төв”-ийг ажиллуулж Улаанбаатар хотын сурталчилгааны материалыг түгээж, олон нийтэд мэдээ мэдээлэл өгч, арга хэмжээг нийт 2000 гаруй хүн үзэж сонирхсон.



✓ “Унгарын соёлын өдрүүд” арга хэмжээ

2.9.5. Унгар Улсаас Монгол Улсад суугаа Элчин сайдын яамтай хамтран “Унгарын соёлын өдрүүд”-ийг Шангри-ла төв болон жанжин Д.Сүхбаатарын талбайд 2022 оны 05 дугаар сарын 13,14-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Унгар улсын ардын болон орчин үеийн соёл урлагийн тоглолт, тойрон бүжиг, гар урлал, бараа бүтээгдэхүүн, Унгар хоолны амталгаа, хүнс, вионы амталгаа, текболын танилцуулга, урлаг соёлын арга хэмжээг зохион байгуулж, жуулчны мэдээллийн төвийг ажиллуулж, Улаанбаатар хотын сурталчилгааны 300 ширхэг материал түгээж, олон нийтэд мэдээ мэдээлэл өгч, арга хэмжээг 2 өдрийн турш нийт 5000 хүн, цахимаар болон шууд дамжуулалтыг 20.000 гаруй хүн үзэж сонирхсон.



“Унгарын соёлын өдрүүд” арга хэмжээг угтан “Монголын Хүүхдийн ордон”, “Монголын Хүүхдийн урлан бүтээх төв”-тэй хамтран “Миний мэдэх Унгар орон” сэдэвт хүүхдийн гар зургийн уралдааныг Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд ангийн сурагчдын дунд зохион байгуулж, ирүүлсэн 209 бүтээлээс 6 шилдэг бүтээлийг шалгаруулж, байр эзэлсэн сурагчдыг “Найрамдал” олон улсын хүүхдийн цогцолборт амрах эрхийн бичиг, өргөмжлөлөөр шагнаж урамшуулав.



✓ **“Талын салхи” олон улсын мото наадам**

2.9.6. Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн шинэлэг хотын аяллын бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох зорилгоор “Монголын чопперчин ахан дүүс” ТББ-тай хамтран “Талын салхи” олон улсын мото наадмыг “Эрүүл хүн-Архигүй Монгол” уриа дор жанжин Д.Сүхбаатарын талбайд 2022 оны 06 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулав.

“Талын салхи” олон улсын мото наадмын үеэр мото дагалдах хэрэгслийн үзэсгэлэн худалдаа, ховор нандин мотоциклын үзүүлэн, танилцуулга, тэмцээн уралдаан, соёл урлагийн тоглолт зохион байгуулагдаж, мото парадад Монгол Улсын 21 аймгийн 45 клубийн 1086, Оросын Холбооны Улсын 114 нийт 1200 мото спорт сонирхогч оролцож, арга хэмжээг 15.000 гаруй хүн үзэж сонирхсон.



✓ **“PLAY TIME” олон улсын амьд хөгжмийн наадам**

2.9.7. Орчин үеийн хөгжмийн урлагаар дамжуулан Улаанбаатар хотыг дэлхийн нийтэд сурталчлах зорилгоор “Плэтайм” олон улсын хөгжмийн наадмыг “Амьд хөгжмийн наадам” ТББ-тай хамтран 20 дахь жилдээ “Visit Ulaanbaatar” уриа дор 2022 оны 07 дугаар сарын 07-10-ны өдрүүдэд Гачуурт тосгон “Монгол шилтгээн” цогцолборт зохион байгуулав.

“Playtime” наадамд 150 гаруй хамтлаг, уран бүтээлчид 15 тайзнаас инди, рок, фолк, метал, жааз, электроник, хип хоп хөгжим зэрэг төрлөөр уран бүтээлээ 60.000 гаруй үзэгчдэд 4 хоногийн турш хүргэсэн.



✓ **“Дээлтэй Монгол наадам 2022”**

2.9.8. Монголчуудын уламжлалт өв соёл, үндэсний хувцасны язгуур хэв шинж, үндэстэн ястны дээл хувцас, эд хэрэглэл, ардын урлагийн биет болон биет бус өвийг сурталчлах, үндэсний хувцсаараа дамжуулан үр хойчдоо түүх, соёл, уламжлалаа өвлүүлэн үлдээх, нийслэл Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгох зорилгоор Соёлын яам, Монголын Аялал жуулчлалын холбоо, “Монгол костюмс” ХХК-тай хамтран “Дээлтэй Монгол наадам 2022” арга хэмжээг 07 дугаар сарын 09-ний өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд 16 дахь жилдээ зохион байгуулав.

“Дээлтэй Монгол наадам”-ын баярын жагсаалд нийслэлийн 6 дүүрэг, Архангай, Баян-Өлгий, Өмнөговь, Дорнод, Сүхбаатар зэрэг 6 аймгийн иргэдийн төлөөлөл, 27 төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүд, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, их, дээд сургууль, Монголын хүүхдийн ордны авьяаслаг сурагчид, морьт харваачид, Монголын бөөгийн холбооны төлөөл зэрэг үндэсний хувцсаар гоёсон 8000 гаруй хүн баярын жагсаалд оролцсон бөгөөд 1000 гаруй гадаадын жуулчид, 10.000 гаруй хүн үзэж сонирхсон.



“Дээлтэй Монгол наадам”-д оролцогчдоос шилдэг дүүрэг, шилдэг байгууллага, шилдэг бүжгийн оролцогч, шилдэг дээл урлаач, хамгийн сайхан дээлтэй гэр бүл /хос/, хамгийн сайхан дээлтэй эрэгтэй, эмэгтэй оролцогч, үндэсний хувцастай гадаадын шилдэг эрэгтэй, эмэгтэй оролцогч, хамгийн сайхан дээлтэй хүүхэд зэрэг 10 номинациар шилдгүүдийг тодруулж шагнал гардуулсан. Шилдэг дүүргээр тэргүүн байранд Сонгинохайрхан дүүрэг, дэд байрт Чингэлтэй дүүрэг, гутгаар байранд Сүхбаатар дүүрэг тус тус шалгарсан.



Нийслэлийн дүүргүүд “Эрийн гурван наадам”, “Монгол үндэстэн, ястны дээл хувцас”, “Дархад, уран бичлэг”, “Монголын үндэсний ахуйн эд хэрэглэл”, “Ардын урлаг” зэрэг сэдвүүдийн хүрээнд гэр хотхоныг тохижуулж, гадаад, дотоодын иргэд, жуулчдад үндэстэн ястны дээл хувцас, эд хэрэглэл, ардын урлагийн биет болон биет бус өвийг сурталчлан таниулах үйл ажиллагааг зохион байгуулсан.



✓ **“Naadam night-2022”**

2.9.9. Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас санаачилгаар Соёлын яам, нийслэлийн Аялал жуулчлалын газар хамтран “Naadam night-2022” арга хэмжээг 2022 оны 07 дугаар сарын 11-ний өдөр Үндэсний соёл, амралтын хүрээлэнд 2 дахь жилдээ зохион байгууллаа.

Үндэсний их баяр наадмын нээлтийг үзэж чадаагүй гадаадын жуулчдад зориулан “Naadam night-2022” арга хэмжээг үндэсний өв соёл шингээсэн эвент, цэнгээнт уралдаанууд, үндэсний их найрал хөгжмийн концерт, уран нугаралт, амьд хөгжим, загварын шоу зэрэг Монгол үндэсний уламжлалт зоог, хувцас, уран зураг, уран дархны гоёлын үзүүлбэр, үндэсний урлагийн гайхамшгийг харуулсан хөгжим, дуу, бүжиг болон дэлхийн сонгодог бүтээлүүдийг хүргэж, гадаадын жуулчдад Монгол өв соёл, ёс уламжлал, үндэсний урлаг, нүүдлийн ахуй соёлыг сурталчилсан бөгөөд гадаад, дотоодын 1500 гаруй жуулчид үзэж сонирхсон.



✓ **“Даншиг наадам-Хүрээ цам 2022” шашин соёлын наадам**

2.9.10. Монгол Улсыг олон улсад сурталчлах, үндэсний өв соёл, ёс заншлаа түгээн дэлгэрүүлэх, дотоодын болон тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дэмжлэгтэйгээр тус газраас Монголын Бурханы шашинтны төв “Гандантэгчэнлин хийд” холбогдох байгууллагуудтай хамтран “Даншиг наадам-Хүрээ цам” шашин соёлын наадмыг 5 дахь жилдээ 2022 оны 08 дугаар сарын 06, 07-ний өдрүүдэд Хүй долоон худагт зохион байгуулав.



“Гандантэгчэнлин хийд”-ийн лам хуврагууд хүрээ цам харайх ёслол, Монголчуудын их шүтээн “Очирваань” бурхны тахилга, Эзэн Богд Чингис хааны тахилга үйлдэж, лам нарын дунд ном хэлэлцэх, мэтгэлцэх, балин тосон урлал, хурал номын ая эгшиг унзад голч нарын тэмцээн тус тус зохион байгуулагдав.



“Даншиг наадам-Хүрээ цам” шашин соёлын наадмын үеэр 256 бөх барилдаан, их нас, хязаалан, жороо морьдын уралдаан, морьт сурын харвааны үзүүлбэр, сурын харвааны тэмцээн, урлаг, шашин соёлын арга хэмжээнүүд зохион байгуулагдаж наадмыг нийт 30.000 гаруй хүн, гадаад улс орны 250 гаруй жуулчин, төлөөлөгчид үзэж сонирхсон.



Хоол үйлдвэрлэл үйлчилгээний 40 гаруй аж ахуйн нэгж асар, гэрээр үйлчилж, шашны эд зүйлс, нарийн хийцтэй бурхдаас эхлээд бүх төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, бизнес эрхлэгчдийн бүтээлээр үзэсгэлэн гаргаж, үндэсний гар урлалын бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид 25 аж ахуйн нэгжүүд наадамчдад худалдаа үйлчилгээ үзүүлэв.



✓ **“Улаанбаатар үндэсний хоолны өдөрлөг”**

2.9.11. “Улаанбаатар үндэсний хоолны өдөрлөг” буюу “UB Food Festival-2022” арга хэмжээг 2022 оны 08 дугаар сарын 20-ны өдөр жанжин Д.Сүхбаатарын талбайд 8 дахь жилдээ зохион байгуулав. Улаанбаатар үндэсний хоолны өдөрлөг” арга хэмжээнд “Намастэ” энэтхэг хоолны ресторан, “Mongolian lamb” ресторан, “Khulan” ресторан, “Black burger” түргэн хоолны ресторан зэрэг 20 ресторан, зоогийн газар, гудамжны хоол үйлчилгээг төлөөлж “Ub street food”, “Food truck” зэрэг газрууд 8 явуулын хоолны газар олон төрлийн хоолыг шинээр санаачлан хийж хоолны цэсээ шинэчлэн оролцсон бөгөөд үндэсний үйлдвэрлэлийн нэрийн бүтээгдэхүүн, үндэсний болон олон үндэсний хоол, зууш амттаны үнэгүй амталгаа бэлтгэж, хямд үнээр иргэдэд үйлчилсэн бөгөөд арга хэмжээний үеэр хүрэлцэн ирсэн зочид, үзэгчид дунд бүргэр, зайрмаг, плов хэн хурдан идэх вэ гэх мэт төрөл бүрийн хоолны тэмцээн, хөгжөөнт тоглоом, урлаг соёл, хоол урлалын сонирхолтой үзүүлбэрүүд зохион байгуулагдаж, арга хэмжээг нийт гадаад, дотоодын 10.000 орчим хүн үзэж сонирхов.



✓ **“Сүүн зам” бүжгийн наадам**

2.9.12. Монгол Улс, Япон Улс дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойн хүрээнд “Сүүн зам” бүжгийн наадмыг 2022 оны 08 дугаар сарын 22-ны өдөр Жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулж, тус наадмыг Япон Улсын Токүшима дахь Монгол Улсын Өргөмжит консул, соёлын элч Каваүчи Широгийн санаачилгаар Монгол Улсад анх удаа зохион байгуулж, Япон Улсаас 160 гаруй хүндэт зочин, төлөөлөгч хүрэлцэн ирсэн бөгөөд наадамд Монгол Японы хамтарсан 500 гаруй бүжигчин оролцож бүжгийн урлагийн үзүүлбэр, бүжгийн парад наадмыг олон нийтэд толилуулав.

Монгол үндэсний гар урлалын болон Япон улсуудын бараа бүтээгдэхүүн, хоол, хүнс, худалдаа, үйлчилгээ, техник технологийг сурталчлахаар 40 гаруй байгууллага өөрсдийн мэдээ, мэдээллийг олон нийтэд сурталчилсан бөгөөд “Сүүн зам” бүжгийн наадмыг гадаад, дотоодын 10.000 гаруй хүн, шууд дамжуулалтыг 25.000 орчим хүн үзэж сонирхсон.



✓ **“Улаанбаатар” олон улсын явган аяллын фестиваль**

2.9.13.Монгол Улсыг олон улсад сурталчлах, дотоодын болон тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх, байгальд ээлтэй аялах дадлыг бий болгох зорилгоор “Зөв, цэвэр аялъя” аяны хүрээнд “Улаанбаатар” олон улсын явган аяллын фестивалийг 4 дэх жилдээ Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газарт 2022 оны 08 дугаар сарын 27-ны өдөр зохион байгууллаа.

Олон улсын явган аяллын фестивалд Бүгд Найрамдах Солонгос Улсын 100, Япон Улсын 10, Монгол Улсын 200 гаруй алхагч, нийт 300 гаруй алхагчид оролцож, Монгол Оллэгийн 3 дугаар маршрутаар нийт 12.8 км замаар аяласан.





✓ **“Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд”**

2.9.14.Бүгд Найрамдах Солонгос улсаас Монгол Улсад Суугаа Элчин сайдын яамтай хамтран “Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд” арга хэмжээг 2022 оны 09 дүгээр сарын 02-04-ний өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгууллаа.

Солонгосын боловсрол, сургалтын байгууллага, аялал жуулчлалын компани, ресторан, төрийн бус байгууллага, тус улсаас бараа бүтээгдэхүүн импортлогч аж ахуйн нэгжүүд, худалдаа, аж үйлдвэрлэл, аялал жуулчлалын салбарын төрийн байгууллагууд зэрэг 26 гаруй байгууллага оролцож, Солонгос хүнсний бүтээгдэхүүн амталгаа, үндэсний хоолны үзүүлбэр, нүүр будалтын шоу, Солонгос улсын ардын урлагийн алдарт “НАНТА”, “Жэй Стик” хамтлагийн урлагийн үзүүлбэр, “Куккивон” таэквондогийн үзүүлэх тоглолт, “Коор” студийн уран бүтээлчид флаш моб, дуу, бүжгийн арга хэмжээ тус тус зохион байгуулагдаж, арга хэмжээг нийт 15.000 гаруй хүн үзэж сонирхсон.



✓ **“Хийморь” олон улсын морьт харвааны наадам**

2.9.15.Монгол Улсыг олон улсад сурталчлах, тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүн, шинэлэг үйлчилгээг бий болгох, жуулчдын сонирхлыг татсан арга хэмжээний тоог нэмэгдүүлэх зорилгоор Монголын морьт харваачдын холбоотой хамтран “Хийморь” олон улсын морьт харвааны

наадмыг 4 дэх жилдээ “Чингис хааны хүрээ” аялал жуулчлалын цогцолборт 2022 оны 9 дүгээр сарын 10, 11-ний өдрүүдэд зохион байгууллаа.

Наадамд Монголын морьт харваачдын холбоо, ОХУ, Өмнөд Африк, Япон, АНУ, Малайз, Израйл улсын харваачид оролцож Олон улсын морьт харвааны холбооны /ИНАА/ Gran Prix тэмцээний дүрмээр Унгар харваа, Турк харваа болон Монголын морьт харваачдын холбооны /МНАА/ Gran Prix тэмцээний дүрмээр Үндсэн таван байны төрөл, Монгол бөмбөг намнаа, Багийн тэмцээн гэсэн 5 төрлөөр нээлттэй зохион байгуулж, арга хэмжээний үеэр морьд харваачдын парад, соёл урлагийн тоглолт, морин циркийн үзүүлбэр, шагайн харваа, сээр шалгах тэмцээн, шонхор шувууны үзүүлбэр, дотоодын үндэсний үйлдвэрлэгч нарын гар урлалын үзэсгэлэн худалдаа зохион байгуулагдаж, наадмыг 150 орчим гадаадын жуулчин, 2000 гаруй хүн, цахимаар 23.750 хүн үзэж сонирхсон.



✓ “Уухай” шагайн харвааны наадам

2.9.16. Монгол Улсыг олон улсад сурталчлах, Юнескогийн хүн төрөлхтний соёлын өвд бүртгэгдсэн Монголын үндэсний уламжлалт спорт-тоглоом шагайн харвааг сурталчлан таниулах, өргөн дэлгэр хөгжүүлэх, уламжлалт ёс жаягийг залуу хойч үедээ өвлүүлэн үлдээх, харваачдын ур чадварыг дээшлүүлэх, дотоодын болон тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор Монголын шагайн харвааны холбоотой хамтран “Уухай” шагайн харвааны наадмыг 2022 оны 11 дүгээр сарын 05,06-ны өдрүүдэд “Скай ресорт” цанын баазад 2 дахь жилдээ зохион байгуулав.

“Уухай” шагайн харвааны наадамд нийт 70 багийн 600 орчим тамирчин оролцсон бөгөөд наадмын шууд дамжуулалтыг 20.000 гаруй хүн үзэж сонирхсон.



2.10.Гадаад, дотоодод зохион байгуулагдах аялал жуулчлалын хурал, зөвлөгөөн, үзэсгэлэн, арга хэмжээнд аялал жуулчлалын болон жуулчны үйлчилгээний байгууллагуудыг хамруулах;

✓ **“Ай Ти Би Берлин” үзэсгэлэн**

2.10.1.Ковид-19 цар тахлаас шалтгаалан виртуал орчинд 2022 оны 3 дугаар сарын 08-10-ны өдрүүдэд цахимаар зохион байгуулагдсан “Ай Ти Би Берлин” үзэсгэлэнд улс, хотуудын төрийн болон аж ахуйн нэгжийн 464 төлөөллүүд оролцож Улаанбаатар хотын арга хэмжээний мэдээллийг байршуулан сурталчлав.

✓ **“Зочид буудал, зоогийн газрын хангамжийн үзэсгэлэн**

2.10.2.Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын Зочид буудлуудын холбоотой хамтран “HOSPITALITY-2022” нэгдсэн арга хэмжээний хүрээнд “Зочид буудал, зоогийн газрын хангамжийн үзэсгэлэн, 2022 оны 05 дугаар сарын 13,14-ний өдрүүдэд Улаанбаатар зочид буудлын үзэсгэлэнгийн танхимд зохион байгуулав. Үзэсгэлэнд орон нутгийн аялал жуулчлалын газрууд, салбарын мэргэжлийн холбоод, зочлох үйлчилгээний чиглэлээр боловсон хүчин бэлтгэдэг их, дээд сургууль зэрэг 45 байгууллага оролцож, арга хэмжээг 5000 гаруй иргэн үзсэн.



✓ **“Улаанбаатар травэл экспо-2022” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэн**

2.10.3. Дотоодын аялагчдад зориулж 21 аймгийн аялал жуулчлалын маршрут мэдээ мэдээлэл, дотоод, гадаадын аяллын бүтээгдэхүүн үйлчилгээг нэг цэгээс хүргэх, хариуцлагатай аялагчийг төлөвшүүлэх зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Улаанбаатар Аялал жуулчлалын холбоотой хамтран “Улаанбаатар травэл экспо-2022” үндэсний аялал жуулчлалын үзэсгэлэнг “Төрсөн нутгаараа аялъя” уриан доор 2022 оны 05 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд 8 дахь жилдээ Мишээл экспо төвд зохион байгууллаа.

Үзэсгэлэнд Баянхонгор, 10 аймгуудын байгаль орчин, аялал жуулчлалын газар, тус аймгуудад үйл ажиллагаа эрхэлдэг жуулчны бааз, рашаан сувиллын газрууд МУБИС зэрэг мэргэжлийн холбоодууд, тур оператор компаниуд, аялал жуулчлалын төсөл хөтөлбөрүүд зэрэг 106 байгууллага оролцож 7000 гаруй иргэдэд мэдээлэл өгч ажилласан.



✓ **“Монголын аялал жуулчлалын форум”**

2.10.4. Монголын Аялал жуулчлалын холбооноос санаачлан Бүгд Найрамдах Солонгос улсын Сөүл, Бусан, Чонжү хот болон Япон улсын Токио, Шизүока, Осака хотуудад 2022 оны 05 дугаар сарын 16-20-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Монголын Аялал жуулчлалын форум” арга хэмжээний үеэр “Ulaanbaatar your gateway” сэтгүүл, “Ulaanbaatar visitors official guide book”, “Ulaanbaatar city map” сурталчилгааны материалыг Бүгд Найрамдах Солонгос Улсын тур оператор, Япон Улсын тур оператор 200 байгууллагын удирдлагуудад танилцуулан Улаанбаатар хотыг сурталчилсан.





✓ **“ЖАТА” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн**

2.10.5. Япон улсын Токио хотноо 2022 оны 09 дүгээр сарын 22-25-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “ЖАТА” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд тус газар болон БОАЖЯ, МИАТ ХК-ний дэмжлэгтэйгээр Шинэ зууч травел ХХК, Жуулчин ХХК, Алтан тур ХХК, Аса травел ХХК, Травел Сэрвис Монголиа ХХК, Чандмань Консалтинг ХХК-ууд оролцож Монгол улс, Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг дэлхийн 78 орны 1018 компани, 122.000 гаруй иргэдэд сурталчлав.

Энэ жилийн үзэсгэлэнгийн онцлог нь ковидын дараах аялал жуулчлалын сэргээх зорилгоор улс, орнууд нэгдсэн зохион байгуулалттайгаар төр, хувийн хэвшил хамтарч оролцсон арга хэмжээний үеэр Япон хэл дээрх “Uaambaatar your gateway” сэтгүүл 330 ширхгийг тарааж ажиллав. “ЖАТА-2022” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд 136 орны 1441 төр, хувийн хэвшлийн байгууллагууд улс, орноо сурталчлан оролцож, үзэсгэлэнг нийтдээ 210.000 хүн үзэж сонирхож байна.



✓ **“Ай Ти Эм” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн**

2.10.6.Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран “Ай Ти Эм” олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнг “Шинэ сэргэлт-Аялал жуулчлал” уриа дор 23 дахь жилдээ 2022 оны 10 дугаар сарын 28,29,30-ны өдрүүдэд “Мишээл экспо” төвд зохион байгууллаа. Нийслэлийн Аялал жуулчлалын газраас өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, улирлын хамаарлыг бууруулах зорилгоор “Ub winter sale” төсөл, www.ubwinter.com цахим хуудсыг олон нийтэд танилцуулж сурталчлан бөгөөд үзэсгэлэнгийн үеэр Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг ажиллуулж 3000 гаруй гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ, мэдээллийг хүргэн ажиллав.

Үзэсгэлэнд 21 аймгийн аялал жуулчлалын бизнес эрхлэгч, аж ахуй нэгж, мэргэжлийн холбоод зэрэг 300 гаруй байгууллага, гадаад улс орноос Турк улс, Оросын Холбооны Улсын Буриад, Тува, Халимаг улсын 60 гаруй аялал жуулчлалын бизнес эрхлэгч, аж ахуй нэгж байгууллагууд оролцож үйл ажиллагаа болон аяллын бүтээгдэхүүнээ танилцуулж, үзэсгэлэнг 10.000 гаруй хүн үзэж сонирхлоо



✓ **“Жежү Олле” явган алхалтын үзэсгэлэн фестиваль**

2.10.7.Бүгд Найрамдах Солонгос улсад 2022 оны 11 дүгээр сарын 02-05-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Жежү Олле” явган алхалтын үзэсгэлэн фестивалд Улаанбаатар хотын аялал жуулчлал болон “Монгол Олле” явган алхалтын талаар танилцуулга, мэдээллийг хүргэж, “Visit Ulaanbaatar сэтгүүл”, “гайд бүүк” 200ш тараан сурталчилж ажиллав. Тус арга хэмжээнд нийт 5 улсын 5000 гаруй төлөөлөгчид оролцсон бөгөөд 3 өдрийн турш 51 км-ийн явган алхалтын замыг туулж маршруттай танилцсан.



✓ **Азийн явган алхалтын замын IV дүгээр чуулган**

2.10.8.Тайван улсад 2022 оны 12 дугаар сарын 01-05-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Азийн явган алхалтын замын IV дүгээр чуулганд АНУ, Австрали, Канад, БНСУ, Япон, Унгар, Путан, Тайван, Монгол зэрэг нийт 9 улсын 400 гаруй зочид төлөөлөгчид оролцсон бөгөөд тус газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, төсөл хөтөлбөр хариуцсан мэргэжилтэн хамрагдаж Улаанбаатар хотын явган алхалтын замын чиглэл болон “Монгол Оллэ” төслийн талаар илтгэл мэдээллийг танилцуулж, Улаанбаатар хотыг сурталчилсан.



✓ **“Цайны зам” олон улсын хурал**

2.10.9.“Цайны зам” Монгол, БНХАУ, ОХУ-ын аялал жуулчлалын салбарын хамтарсан хурал 2022 оны 07 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулагдаж, хуралд 3 улсын 200 гаруй албан тушаалтан оролцож “Цайны зам” олон улсын аялал жуулчлалын холбооны дүрмийн нэмэлт өөрчлөлтийг батлах, Монгол Улсын Говь-сүмбэр аймаг, Хэнтий аймаг, ОХУ-ын Хабаровскийн хязгаар, Приморийн хязгаар зэрэг аймаг, мужуудыг гишүүнээр элсүүлэх асуудлыг хэлэлцсэн шийдвэрлэсэн.



2.11.Нийслэлийн аялал жуулчлалын нөөцөд түшиглэн аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, шинээр бий болгох ажлыг зохион байгуулах;

2.11.1. Улаанбаатар хотын аяллын шинэ бүтээгдэхүүн бий болгох, зорин очих газрын тоог нэмэгдүүлэх, түүх соёлын дурсгалыг хадгалан хамгаалах, аялал жуулчлалын эргэлтэд

оруулах зорилгоор “Их тэнгэрийн амны хадны зургийн орчныг тохижуулах ажил”-ыг “Жи Эн Зэт Эф Икс” ХХК-аар гэрээгээр гүйцэтгүүлж, тохижилтын ажлыг 2022 оны 04 дүгээр сараас эхлүүлж, явган хүний зам, авто машины зогсоол /12/, хадны зураг руу гарахад зориулсан шат, сандал, танилцуулга самбар, ногоон байгууламжийн ажлууд хийгдэж, нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 383 жилийн ойг угтан 10 сарын 27-ны өдөр тохижилтын нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулж, аялал жуулчлалын эргэлтэд оруулж, соёлын үл хөдлөх дурсгалыг иргэд, жуулчдад үзэх боломжийг бүрдүүлсэн юм.



2.11.2. Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг түшиглэн хөгжүүлж, аяллын эргэлтэд оруулах ажлын хүрээнд нийслэлийн Хөрөнгө оруулалтын газраар Туулын хар Түнийн ордны туурийн зураг, төсөв боловсруулах даалгаврыг батлуулсан.

БАТЛАХ НИЙСЛЭЛИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГА Б.МӨНХБАТ	
УЛААНБААТАР ХОТ ОРЧМЫН ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛЫГ ТҮШИГЛЭН ХӨГЖҮҮЛЖ, АЯЛЛЫН ЭРГЭЛТЭД ОРУУЛАХ АЖИЛ УЛААНБААТАР ХОТЫН ЗУРАГ, ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР	
2022 оны 08-р сарын 25-ны өдөр № 1023/15.8 Улаанбаатар хот	
1. Зураг төсөл боловсруулах үндэслэл	Нийслэлийн Засаг даргаар 2022 оны 02 дугаар сарын 18-ны өдөр А/219 дугаар захирамж
2. Байршил, нэрлэл, газрын хэмжээ	- Хан-Уул дүүрэг, 13 дугаар хороо, Туулын хар түнийн ордны тухай
3. Зорилго, хүчин чармайлт	- Төхөөмөл
4. Төсөл гүйцэтгэх хугацаа	- Захиалгыг гүйцэтгэх талуудын хооронд байгуулан гарахад авсан хугацааг үндэслэл болгоно
5. Байршил үндсэн бүтэц, материал	- Төсөлөөр
6. Икөөний дүгнэлт, буцаад төлөгдөх шаардлага	- Төсвийн нэгдэл шаардлагатай бол аялалын төсөж ирэхийг байгууллагуудад шамаар төхөөмөлийн нөхцөлүүдийг гаргуулах. Тус төхөөмөлийн нөхцөлийн хүрээнд гадна икөөнийг шугам, хувиартай зургийг төсөв боловсруулах, төхөөмөлийн нөхцөл олгогдохгүй тохиолдолд өөрийн эрх үүсвэрээр икөөнийг шугам, орчинтай зураг төсөв боловсруулах холбогдох байгууллагуудтай амжилтын батлуулах.



2.11.3. Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг түшиглэн хөгжүүлж, аяллын эргэлтэд оруулах төсөл, арга хэмжээний хүрээнд “Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булш” цогцолборын ажлын гүйцэтгэгчээр шалгарсан “Өндөрхаан-Өргөө” ХХК-тай гэрээ байгуулж, тохижилтын ажлыг 2022 оны 08 сараас эхлүүлсэн.

Жуулчдын зорин очих газрын дэд бүтцийг сайжруулж, бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд “Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булш” цогцолборын батлагдсан зураг, төсвийн дагуу авто машины зогсоол, гадна хашаа, ариун цэврийн байгууламж, мод бут суулгах ажлыг гүйцэтгүүлж, хяналт тавьж ажилласан бөгөөд он дамжин хийхээр шийдвэрлэгдсэн.




2.11.4. Нийслэл Улаанбаатар хот үүсэн байгуулагдсаны 383 жилийн ойн хүрээнд “Хүн номадик” ХХК, “Үндэсний соёл амралтын хүрээлэн” ХХК-тай хамтран “Дэлхийн урлагийн голомт” хадны зургийн ил үзэсгэлэнгийн нээлтийн үйл ажиллагааг 2022 оны 10 дугаар сарын 27-ны өдөр зохион байгуулж 5 хадны зураг байршуулсан бөгөөд цаашид 26 түүх соёлын үл хөдлөх дурсгал, соёлын өв болох хадны зургуудыг байршуулан ил үзмэрийг иргэд, жуулчдад танилцуулах, үзэх боломжийг бүрдүүлэх юм.



2.12. Гадаад, дотоодын жуулчдыг хэрэгцээт мэдээллээр хангах, мэдээллийн товхимлуудыг тогтмол шинэчлэх, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх;

2.12.1. Улаанбаатар хотын сурталчилгааны “Ulaanbaatar your gateway” сэтгүүлийн мэдээллийг шинэчлэн Солонгос, Япон хэл дээр 2000 ширхэг, “Сити тур” аяллын танилцуулга, газрын зураг 2500 ширхэг нийт 5500 ширхэг сурталчилгааны материал хэвлүүлж, гадаад, дотоодын үзэсгэлэн, арга хэмжээнд иргэд хүргэж Улаанбаатар хотыг сурталчилан, “Ulaanbaatar your gateway сэтгүүл”-ийг Англи, Орос, Герман хэлээр, “Ulaanbaatar official visitors guidebook”, газрын зураг зэрэг сурталчилгааны материалуудын дизайн загварыг шинэчилэн хэвлэх ажлыг зохион байгуулж байна.






2.12.2. Нийслэлийн хэмжээнд соён гэгээрүүлэх ажлыг зохион байгуулах арга хэмжээний хүрээнд “Бүх нийтийн аяллын боловсролыг нэмэгдүүлэх” аяныг “Зөв аялъя”, “Цэвэр бай” уриа дор “Joinme”, “Нона фамили” ХХК, “Цэвэр ЭНОА” - “Мисс Монголиа”, зэрэг аялал жуулчлалын байгууллагуудтай хамтран аяллын боловсролыг нэмэгдүүлэх уриалга, зөв аялах дадлыг хэвшүүлэх талаар 20 удаагийн зурагт болон видео мэдээлэл гарган 60.536 мянга хүнд хүргэж, олон нийтэд сурталчлан таниулсан.

“Зөв цэвэр аялъя” уриатай зургийг хүрээг гарган 2022 онд зохион байгуулагдсан 8 арга хэмжээ болон жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүдээр дамжуулан 15.000 гаруй хүнд сурталчилсан.





2.12.3. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/599, А/1324 дүгээр захирамжуудын дагуу “Улаанбаатар хотыг сурталчлах ажлыг цахим болон виртуал хэлбэрээр зохион байгуулах” ажлын хүрээнд Нийслэлийн Бизнес инновац хөгжлийн газартай хамтран Google street view төслийн хүрээнд холбогдох гэрээг байгуулан ажиллаж байна. Энэхүү гэрээний дагуу Богдхан уулын Зайсан-Дугуй цагаан-Баруун ширээт /13км/ гэсэн маршрутын зураглалыг авч ажилласан бөгөөд Улаанбаатар хотод байх жуулчдын хамгийн ихээр үздэг 2 музей болон түүх, соёлын 4 олдворын зураг авалтын ажил хийгдэж байна.



2.12.4. Улаанбаатар хот болон аялал жуулчлалын гадаад сурталчилгааны мэдээ мэдээллийг багтаасан “Visitulaanbaatar” цахим сэтгүүлийг Англи Монгол хэлээр гаргаж, QR code үүсгэн, сурталчилгааны материал болгон гадаад хэргийн ямаар дамжуулан ЭСЯ, Консулын газруудаар дамжуулан ажилласан.

Улаанбаатар хотыг гадаад улс оронд сурталчлах www.Visitulaanbaatar.net цахим хуудсанд хөгжүүлэлт хийж жуулчдад хэрэгцээт цаг үеийн шинж чанартай мэдээ, мэдээллийг тогтмол /англи хэл дээр бэлтгэн/ оруулж нийт 25,406 хүнд сурталчилсан. Цахим сайтын мэдээг эх сурвалжаас 54.1%, facebook хуудаснаас 15.8%, Google-ээс 30.1% үзэж, Улаанбаатар хотын өнгө төрхийг харуулах 360 градусын 4 багц 25 ширхэг зургийн санг үүсгэн байршуулж, нийслэлийн мэдээ мэдээллийн www.Ulaanbaatar.mn цахим хуудастай холбож үйл ажиллагааг олон нийтэд сурталчилсан.

Байгууллагын www.tourism.ub.gov.mn цахим хуудсанд 20,000, www.visitulaanbaatar.net цахим хуудсанд 25,406, facebook хуудсанд 747,000 гаруй хандалттай байна.

2.13. Нийслэлийн хэмжээнд аялал жуулчлалын салбарын мэдээллийн санг хөтлөх;

2.13.1. Улаанбаатар хотод идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллага, олон улсын чанартай зохион байгуулагддаг аялал жуулчлалын томоохон үзэсгэлэн, арга хэмжээ болон хот орчмын болон аймаг орон нутгийн очиж үзэж болох дурсгалт газрууд,

аяллын маршрут, тусгай сонирхлын аялал зохион байгуулдаг сайн дурын клубүүдийн судалгааг шинэчлэн гаргаж мэдээллийн сан үүсгэсэн.

Жуулчны мэдээллийн санд нийт 17 төрлийн багц 25 ангиллаар 8000 гаруй аж ахуй нэгж байгууллага, үзвэр үйлчилгээг багтаасан нэгдсэн мэдээллийн санг тогтмол шинэчлэн гадаад, дотоодын иргэд, жуулчдыг хэрэгцээт мэдээллээр ханган ажилласан.

2.13.2.Байгууллагын үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоотой үзүүлэлт, тоон мэдээлэл болон үзвэр, үйлчилгээний газар, сүм, хийд /шашны ангиллаар/, бэлэг дурсгалын дэлгүүр, гар урлалын төвүүдийн тоо, түүх соёлын үл хөдлөх дурсгал, ресторан, баар, цэнгээний газрын тоон мэдээлэл үүсгэж, танилцуулгын хамт нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн.

2.14.Жуулчны мэдээллийн төвүүдийн үйл ажиллагааг өргөжүүлэх

2.14.1.Гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилгоор Нийслэлийн Засаг захиргааны IV байр, “Тэрэлж-Монгол олле”, “Хонхор тосгон-Монгол олле”, “Сөүлийн гудамж-Монгол олле” зэрэг байршлуудад “Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүд”-ийг ажиллуулж, Улаанбаатар хотын жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг “Төв шуудан”-д 2022 оны 09 дүгээр 05-ны өдрөөс, ХБНГУ-ын “Фрайбург” хотын Соёлын байранд 2022 оны 10 дугаар сарын 22-ны өдрөөс байгуулж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн явуулсан.



2.15.Жуулчдын санал, гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх;

2.15.1.Жуулчдын санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх, мэдээлэл, зөвлөгөөг түргэн шуурхай, цаг алдалгүй хүргэх зорилгоор жуулчны мэдээлэл, сурталчилгааны 5 төвөөр 15.000 гаруй гадаад, дотоодын иргэд, жуулчдад мэдээ, мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа.

Гадаад, дотоодын иргэд, жуулчдад зориулан зохион байгуулсан 15 арга хэмжээ, үзэсгэлэнгийн үеэр явуулын мэдээлэл сурталчилгааны цэгийг ажиллуулж, нийслэл Улаанбаатар хотын сурталчилгааны тараах материал 20.000 олгож, нийт 115.000 гаруй гадаад, дотоодын иргэд, жуулчдад мэдээлэл, зөвлөгөө өгч, Улаанбаатар хотын аялал жуулчлалыг сурталчилж ажиллав.






2.16.Гадаад, дотоодын жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй орчинд зорчих, аялах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр холбогдох төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах.

2.16.1.Гадаад, дотоодын иргэд, жуулчдыг гэмт хэрэг, зөрчилд өртөхөөс урьдчилан сэргийлэх, аюулгүй аялах видео контент, аяллын үед коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж бүхий 2 төрлийн контентыг зочлох үйлчилгээний 30 байгууллагын угтах үйлчилгээ, хүлээлгийн танхимд байршуулж, агаарын тээврийн МИАТ ХК, Аеро Монголиа ХХК, Хүннү эйр ХХК Түркиш эйрлайнс, Аерофлот компаниудын төлөөлөгчийн газруудад, Монголын зочид буудлуудын холбоо ТББ, Монголын жуулчны баазын хөгжил холбоо ТББ, Өргөө дэн буудлын холбоо ТББ-уудад 2 төрлийн контентыг хүргүүлж ажилласан. “Улаанбаатар хотын зочид буудлуудын нэгдсэн мэдээлэл”, “Улаанбаатар хотын дэн буудлуудын нэгдсэн мэдээлэл”, “Улаанбаатар хотын амралтын газар, жуулчны баазуудын мэдээлэл” групп-т контентыг байршуулан 26.400 хүнд хүргэж ажиллаа.

2.16.2.Монгол Улсад аялах хугацаандаа коронавирусын халдвараас урьдчилан сэргийлж, халдвар хамгааллын дэглэм, зөвлөмжийг дагаж мөрдөх санамж, жуулчны мэдээллийн төвийн мэдээлэл, шаардлагатай утасны жагсаалт болон урьдчилан сэргийлэх санамж бүхий 2 төрлийн 10.000 ширхэг санамжийг “Жуулчны мэдээлэл, сурталчилгааны 5 төв, жуулчин цагдаа болон зохион байгуулсан 15 арга хэмжээний үеэр гадаад дотоодын иргэд жуулчдад тараасан.



✓ **“Оюутан цагдаа-2022”**

2.16.3.Гадаад, дотоодын жуулчдад хэрэгцээт мэдээ, мэдээллийг хүргэх, эрх зүйн туслалцаа үзүүлэх зорилготой “Оюутан цагдаа-2022” арга хэмжээг Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Монголын Оюутны холбоотой хамтран 2022 оны 06 дугаар сарын 20-ноос 08 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд жуулчдын ихээр зорчдог гудамж талбай,

олон нийтийн газруудад Үндэсний их баяр наадам болон бусад арга хэмжээнүүдэд нийт 150 “Оюутан цагдаа” ажиллаж, үүрэг гүйцэтгэх хугацаандаа гэмт хэргийн 91, зөрчлийн шинжтэй 412 дуудлага, мэдээлэл, 14 гэмт хэрэг, 164 зөрчлийг илрүүлэн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад өгч, дотоодын 16989, гадаадын 2171 жуулчин, иргэдэд хэлмэрчлэн, туслалцаа үзүүлж, 36296 ширхэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зурагт хуудас, сэрэмжлүүлэг тараах ажлыг хийж гүйцэтгэв.



Гурав.Дотоодын болон өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын хүрээнд:

✓ “Сити тур төсөл”

2.3.1.Улаанбаатар хоттой танилцах жишиг аялал, “Танин мэдэхүйн аялал”, “Сурагчдад зориулсан аялал”, “Ахмадуудад зориулсан аялал”, “Түүхэн дурсгалт газруудын аялал”, “Эко аялал” зэргээр 20 гаруй хотын аяллын маршрутыг батлуулан “Сити тур” төслийг 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 10 дугаар сарын 31-ний өдрийн хугацаанд хэрэгжүүлж, нийт 92 удаагийн аяллаар 4885 дотоодын болон гадаадын жуулчдын хамруулан Улаанбаатар хотын аяллыг зохион байгууллаа.





✓ “Study tour”

2.3.2.Зохистой хөдөлмөр эрхлэлтийн талаар залуучуудад мэдлэг мэдээлэл өгөх, ажлын байранд түр болон байнгын ажлын байртай болох боломжийг бий болгох төр, төрийн бус, олон улсын байгууллага болон хувийн аж ахуйн нэгж, бизнесийн хамтран ажиллагч, дэмжигч байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаатай богино хугацаанд бодит, практик хэлбэрээр танилцаж, туршлага судлах боломжийг бүрдүүлэх зорилгоор “Study tour” аяллыг шинээр нэвтрүүлж, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, “Талх Чихэр” ХК, “АПУ” ХК 3 байгууллагын үйл ажиллагаатай таницлах аяллыг зохион байгуулж 200 гаруй залуучуудыг хамруулав.



✓ **“Их түүхийн жимээр” сургалт- аялал арга хэмжээ**


2.3.3.Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх, сурагчдад аяллын боловсрол олгох зорилгоор “Их түүхийн жимээр” сургалт- танин мэдэхүйн аялал арга хэмжээг 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулав.

Улаанбаатар хот орчмын “Чингисийн хүрээ жуулчны бааз”, Сонгинохайрхан уулын өвөрт орших “Туулын хар түнийн ордны туурь”, “Сонгинохайрханы овоо”, “Айдсын давааны овоо”, “Нүхтийн аман дахь бичигт хад”, “Соёмбот толгойн овоо”, “Чандмань толгойн овоо”, “Яармагийн дэнж”, “Туул гол”, “Богд хан уул”, “Зайсан толгой”, зэрэг түүхэн дурсгалт газруудаар аялж, Богд хааны ордон музей, Нисэхийн түүхийн музейтэй танилцах сургалт- аялал арга хэмжээнд 3 сургуулийн ахлах ангийн 45 сурагч хамрагдлаа.



✓ **“Ub winter sale” төсөл**

2.3.4.Жуулчны улирлыг уртасгах, өвлийн улиралд зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор “UB WINTER SALE” арга хэмжээг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд “Тану Партнерс” ХХК-тай хамтран хэрэгжүүлж, www.ubwinter.com вэб сайтыг ашиглалтад оруулж өвөл зорин ирэх жуулчдад хөнгөлөлт үзүүлэх, аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг нэг дороос авах боломжийг бүрдүүлэн цахим шар номыг бий болгох, жуулчдад хүртээмжтэй, мэдээллийг түргэн шуурхай хүргэх зорилгоор гар утасны аппликешнийг бий болгосон.



✓ **“Өвлийн аялал жуулчлал асуудал, шийдэл” хэлэлцүүлэг**

2.3.5. Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Аялал жуулчлалын зөвлөл, Монголын зочид буудлуудын холбоотой хамтран “Өвлийн аялал жуулчлал асуудал, шийдэл” хэлэлцүүлгийг 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулж, хэлэлцүүлэгт “Хүннү айр”, “Жуулчин”, “Тану тур”, “Wonder Mongolia” зэрэг аялал жуулчлалын тур оператор компанийн 50 гаруй төлөөлөл оролцож, өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тулгарч буй хүндрэл бэрхшээл, асуудал шийдлийн талаар хэлэлцсэн бөгөөд тус газраас “Хотын өвлийн аялал”, “Хүннү Айр” компаниас “Өвлийн аялал жуулчлал ба агаарын тээвэр: Манжуурын өвлийн аяллын жишээ”, “Тану партнерс” ХХК-аас “UB winter sale төсөл”- ийн талаар танилцуулга хийгдлээ.




ХӨТӨЛБӨР	
09:30	Бүртгэл (Цай / Кофе)
10:00	Нээлт МУХАУТ-ын дордаж Аялал Жуулчлалын Зөвлөлийн дарга Б.Барсболд
10:10	“Хотын өвлийн аялал” Нийслэлийн аялал жуулчлалын газрын Захиргаа, санхүүгийг хэлтсийн дарга Х.Содномдамбырал
10:30	“Өвлийн аялал жуулчлал ба агаарын тээвэр: Манжуурын өвлийн аяллын жишээ” “Хүннү Айр” компанийн захирал П.Мөнхжаргал
10:50	Саяал асуулга, хэлэлцүүлэг: “Хот орчимд өвлийн аялал хийхэд тулгарч буй асуудлууд”
11:40	Хэлэлцүүлгийн үр дүнг танилцуулах



✓ **“Грийн фестивал-31 мод”**

2.3.6. Улаанбаатар хотын өвлийн аялал жуулчлалыг сурталчлах, аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгон хөгжүүлж зорилгоор Байгаль орчин, аялал жуулчлалын яамтай хамтран “Олон улсын өвлийн аялал жуулчлалын өдрүүд” буюу “Грийн фестивал-31 мод” арга хэмжээг жанжин Д.Сүхбаатарын талбайд 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхэлж, төлөвлөгөөний дагуу ажиллаж байна.



✓ **“Шинэ жилээр Монголд”**

2.3.7. “Шинэ жилээр Монголд” өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд Оросын Холбооны Улсын хил орчмын мужуудаас жуулчид хүлээн авах, бэлтгэх хангах ажлын цахим хурал 2022 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулагдав. Хурлыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан

удирдан явуулж, хуралд Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны холбогдох гишүүд, хил орчмын буюу Баян-Өлгий, Увс, Хөвсгөл, Сэлэнгэ, Дорнод зэрэг 10 аймгийн Засаг дарга нар оролцсон бөгөөд “Шинэ жилээр Монголд” өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх хөтөлбөрийн танилцуулга хийж, Оросын Холбооны Улсын жуулчдыг хүлээн авах чиглэлээр анхаарах асуудлын хүрээнд мэдээллийг сонсож хэлэлцсэн.

“Шинэ жилээр Монголд” арга хэмжээний хүрээнд 10-70 хувь хүртэлх үйлчилгээ нь хямдрах боломжтой 16 зочид буудал байршуулах үйлчилгээний байгууллагуудыг нэгдсэн цахим хэлбэрт оруулан сурталчлан ажилласан.

Дөрөв.Хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийн хүрээнд:

2.4.1. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн өмнө газрын дарга “Хариуцлагын гэрээ”-ээр хүлээсэн үүргийн хэрэгжилтийг хангаж ажиллах ажлын хүрээнд Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийн Хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилтын хэрэгжилтийг хангах, төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн санал хүсэлт, өргөдөл гомдлыг хугацаанд нь шийдвэрлэн хариуг шуурхай өгч, хүнд суртал, чирэгдэлгүй ажиллах, гэрээний хэрэгжилтийг тайлаглах зэрэг 17 заалт бүхий үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан баталж, төлөвлөгөөний хэрэгжилт 97.8 хувийн гүйцэтгэлтэй биелсэн.

2.4.2. Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/01 дүгээр захирамжаар 2022 оныг “Хотын иргэний жил” болгон зарласантай холбогдуулан нийслэлийн нэгдсэн төлөвлөгөөтэй уялдуулан тус газраас дүрэм, стандартыг сурталчлах, хотын соёлыг төлөвшүүлэх, хөдөлмөр эрхлэлт, орлого нэмэгдүүлэх, амьдрах орчныг сайжруулах чиглэлээр 4 зорилтын 15 арга хэмжээний төлөвлөгөөг баталж олон талт ажлыг зохион байгуулж, “Хотын иргэний жил”-ийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 2022 оны жилийн эцсийн байдлаар 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн.

2.4.3.Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 360 дугаар тогтоолоор нийслэлийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд Аялал жуулчлалын газар ажиллуулахаар тогтоосонтой холбогдуулан Газрын дүрмийг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцүүлэн шинэчлэн боловсруулан нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлуулсан. Газрын дүрмээр хүлээлсэн үндсэн чиг үүргийн 15 заалтын 54 арга хэмжээний биелэлт 95.7 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн.

2.4.4.Байгууллагын 2021 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн хяналт шинжилгээ, үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх 5 зорилтын 31 арга хэмжээ хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө боловсруулж газрын даргаар батлуулж, хэрэгжилт 2022 оны жилийн эцсийн байдлаар 98.6 хувь биелсэн.

2.4.5.Нийслэлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх “Найрсаг Улаанбаатар-2” арга хэмжээг Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/599 дүгээр захирамжаар батлуулсан. Арга хэмжээний үйл ажиллагааны төлөвлөгөөг хамтран хэрэгжүүлэх байгууллагуудад мэдээллийг хүргүүлж ажилласан. Арга хэмжээнд 7 зорилтын 77 арга хэмжээ тусгагдсан ба хамтран хэрэгжүүлэгч байгууллагуудаас жилийн эцсийн тайланг авч, нэгтгэн ажиллаж байна.

2.4.6.Ковидын дараах Нийслэлийн аялал жуулчлалыг сэргээж хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г Монгол Улсын Засгийн газрын “Шинэ сэргэлтийн бодлого”-той уялдуулан боловсруулж, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Аялал жуулчлалын Зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

2.4.7.Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журам”-аар нийслэлийн Засаг даргын агентлагын дарга тамга хэрэглэх болсонтой холбогдуулан хүсэлтийг хүргүүлж, дүрэм, журамд нийцүүлэн тамга, тэмдэг шинээр хийлгэх ажлыг гүйцэтгүүлж, үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан.

2.4.8.Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 07 дугаар сарын 11-ний өдрийн “Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай” 159 дүгээр зарлигийн хэрэгжилтийг хангаж Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залах ёслолын үйл ажиллагааг зохион байгууллаа.



2.4.9.“Аажуу явбал аяндаа хүрнэ”, “Хичээх өдөр”, “Намайг алгас” аяны мэдээллийг байгууллагын цахим хуудсаар дамжуулж түгээсэн. Жендэрийн үндэсний хорооноос зохион байгуулж буй “Жендэрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх 16 хоногийн аян”-ны мэдээллийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд түгээн ажиллаж байна.

2.4.10.Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” А/1357 дугаар захирамжийн хэрэгжилтийг ханган Нийслэлийн Онцгой комиссын даргын баталсан “Сайжруулсан шахмал түлш болон түүхий нүүрсний хэрэглээнд хяналт тавьж, мэдээлэл өгч ажиллах байгууллага, албан тушаалтны хуваар”-ийн дагуу Чингэлтэй дүүргийн 17, 18 дугаар хороод тогтмол ажиллаж байна.

Сайжруулсан шахмал түлшний 12 борлуулалтын цэгт тогтмол хяналт тавьж, мэдээ тайланг холбогдох газруудад хугацаанд нь хүргүүлэн ажиллаж байгаа бөгөөд хороодын Засаг даргын ажлын албатай хамтран эрсдэл бүхий айл өрхөөр орж зуух, пийшингийн аюулгүй байдлыг хангах, зөв галлагааны талаар заавар зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулсан.



✓ **Архив, албан хэрэг хөтлөлт шийдвэрлэлт:**

2.4.11.Архив, албан хэрэг хөтлөлтийн хууль, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 246 дугаар тогтоолоор батлагдсан “Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”, 2021 оны 226 дугаар тогтоолоор батлагдсан “Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас, хийлгэх журам болон стандартын хүрээнд газрын даргын 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/35 дугаар тушаалаар байгууллагын үйл ажиллагаанд мөрдөх “Архив, албан хэрэг хөтлөлтийн журам”-ыг шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдөн ажилласан.

2.4.12.Байгууллагын баримтын данс бүртгэлийг нийслэлийн Баримт нягтлан шалгах арга зүйн комиссын хурлаар батлуулж, байнга хадгалах 356, түр хадгалах 620, 70 жил хадгалах 30, гэрэл зургийн 34, дүрс бичлэгийн 20, устгах хэргийн 15 нэр төрлийн 151 баримт буюу нийт 1211 баримтаас төрийн архивт байнга хадгалах 356, гэрэл зургийн 34 хадгаламжийн нэгжийн 6082 зураг, дүрс бичлэгийн 20 хадгаламжийн нэгжийн 24 цаг 3 минут 5 секунд бүхий дүрст баримтыг Төрийн архивын шилжүүлэх ажлыг зохион байгуулсан.

2.4.13.Тус газарт 2022 оны 11 сарын 30-ны өдрийн байдлаар төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, аж ахуй нэгжээс ирүүлсэн 589 албан бичгийг бүртгэж, албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартад нийцүүлэн 554 албан бичгийг явуулсан.Ирүүлсэн 589 албан бичгээс шийдвэрлэсэн 583, 6 албан бичиг судалж байгаа төлөвтэй байна. Албан хэрэг хөтлөлтийн зөрчил өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 нэгжээр буурсан, шийдвэрлэлт 99.06 %-тай байна.

✓ **Өргөдөл, гомдлын шийдвэрлэлт:**

2.4.14.Тайлант хугацаанд нийт 24 өргөдөл, гомдол, санал, хүсэлт ирүүлснээс захиргаа, хүний нөөцийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 22, иргэдээс бусад чиглэлээр 2 өргөдөл, гомдол, санал хүсэлт ирүүлснийг 100% эцэслэн шийдвэрлэж хуулийн хугацаанд иргэнд хариу өгч ажилласан.

Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд нь шийдвэрлээгүй, зөрчил бүртгэгдсэн албан хаагч болон хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй болно. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 5 хоног 16 цаг 44 минут байна

Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн тайлан мэдээг нийслэлийн Үйлчилгээний нэгдсэн төвд тогтоосон хугацаанд нь хүргүүлж, байгууллагын www.tourism.ub.gov.mn цахим хуудаст ил тод, нээлттэй байршуулсан.

✓ **Худалдан авах ажиллагаа, төсөл арга хэмжээ:**

2.4.15.Нийслэлийн Засаг даргын 2022 оны “Эрх шилжүүлэх тухай” А/219 дүгээр захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2022 онд санхүүжүүлэх Улаанбаатар хот орчмын түүх, соёлын дурсгалыг түшиглэн хөгжүүлж, аяллын эргэлтэд оруулах төсөл, арга хэмжээний эрхийг нийслэлийн Аялал жуулчлалын газарт шилжүүлж, НХААГ/202212090 тендер шалгаруулалтын дугаартай 1,000.0 төсөвт өртөгтэй 3 багц төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан.

НХААГ/202212090-1 багц ажил буюу “Бэлхийн амны Хүннүгийн язгууртны булш” цогцолборын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ байгуулах, эрх олгох зөвлөмжийг хүргүүлэн тохижилтын ажлын зураг, төсвийг Барилгын хөгжлийн төвд хүргүүлж, экспертийн томилгоог хийлгэж, магадлалаар оруулсан.

Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн холбогдох заалтын хүрээнд НХААГ/202212090-2 багц буюу “Гачууртын амны хадны зураг”, НХААГ/202212090-3 багц буюу “Ар гүнт дэх дөрвөлжин булш” түүх, соёлын дурсгалын орчныг тохижуулах ажлын хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах

ажиллагаа зогссон бөгөөд явцын мэдээллийг <https://report.ub-procurement.mn/> цахим хаягт тухай бүр оруулан ажиллаж байна.

Тав.”Хүний нөөцийн хөгжил, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд:

2.5.1.“Албан хаагчдын сургалтын хөтөлбөр”-ийн хүрээнд 2022 оны сургалтын төлөвлөгөөний дагуу нийт 37 төрлийн сургалтад 121 /давхардсан тоогоор/ албан хаагчийн хамруулсан. Төрлөөр нь авч үзвэл гадаадын 4 сургалт, дотоод 33 сургалт зохион байгуулж, давтан сургах буюу ажлын байрны сургалт 12, мэргэшүүлэх дунд болон богино хугацааны сургалтад 10, бусад төрлийн сургалт 11 удаа тус тус зохион байгуулсан.



2.5.2.Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн хүрээнд 7 зорилтын 15 ажил арга хэмжээг төлөвлөн бүрэн хэрэгжүүлж ажилласан.Тухайлбал:

Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Албан тушаалын тодорхойлолт боловсруулах нийтлэг журам”-д хүрээнд тус газрын 14 албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж хянуулан танилцуулж, Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 323 дугаар тогтоолын хүрээнд газрын даргын 2022 оны А/24 дүгээр тушаалаар төрийн захиргааны /ТЗ/ 14, төрийн үйлчилгээний /ТҮ/ 3 нийт 17 албан тушаалын тодорхойлолтыг батлуулсан.

Монгол Улсын Засгийн газрын 2022 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай” 192, 194 дүгээр тогтоолоор төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлд өөрчлөлт орж батлагдсантай холбогдуулан газрын даргын 2022 оны Б/24 дүгээр тушаалаар 18 албан хаагчийн албан тушаалын цалин, ангилал, зэрэглэлд өөрчлөлт оруулж баталсан.

Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/452 дугаар захирамжаар газрын 4 албан хаагчид зэрэг дэв олгуулж, Төрийн албаны тухай хууль тогтоомжийн хүрээнд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, зэрэг дэвийн нэмэгдэл, бусад нэмэгдэл хөлсийг Төрийн албаны тухай хууль тогтоомжид заасны дагуу олгосон.

ГУРАВ. БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ:

3.1.1.Байгууллагын алсын хараа, эрхэм зорилго, дүрэм, бүтэц, чиг үүрэг болон үйл ажилланааны тайлан холбогдох дүрэм журам, шийдвэрүүдийг байгууллагын цахим хуудсанд байршуулж, тэдгээрийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлан, үр дүнг <https://tourism.ub.gov.mn/> сайтад тухай бүр шинэчилэн байршуулав.

3.1.2.Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай, Шилэн дансны тухай хууль, Авлигын эсрэг үйл ажиллагааны дагуу Эрхэм зорилго, үйл ажиллагааны зорилт, зорилго, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээллийг

<https://tourism.ub.gov.mn/?cat=27-нд> байршуулан ил тод байдлыг ханган ажилласан бөгөөд байгууллалгын үйл ажиллагаатай холбоотой 1748 мэдээ, мэдээлэл бэлтгэж газрын веб сайт болон пэйж хуудаст нийтэлж, олон нийтэд сурталчилсан.

3.1.3. Албан хаагчдын нэр, албан тушаал, харилцах утас, цахим хаяг, байгууллагын мөрдөгдөж байгаа дүрэм, журам, сарын төсвийн хуваарь, гүйцэтгэлийг байгууллагын цахим хуудас, мэдээллийн самбарт тухай бүр шинэчлэн байршуулав.

3.1.4. Авлигалаас урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд 3 зорилтын 12 арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт 100 хувь хэрэгжсэн бөгөөд Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт болон Авилагтай тэмцэх газрын Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн дүгнэлтийг үндэслэн удирдах албан тушаалд 1, гүйцэтгэх албан тушаалд 3, нийт 4 албан хаагчийг томилж, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 194 дүгээр тогтоолын хүрээнд ТЗ-6 ангилал руу шилжсэн 10 албан хаагч, хөрөнгө орлогод их хэмжээний өөрчлөлт орсон 2 албан хаагч, шинээр томилогдсон 2 албан хаагч хөрөнгө орлогын мэдүүлгийн хуулийн хугацаанд гаргаж холбогдох газарт тайлагнасан.

3.1.5. Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/1059 дүгээр захирамжаар тус газрын бүтэц, орон тооны хязгаарыг 18, Захиргаа, санхүүгийн хэлтэс, Бодлогын хэрэгжилтийн хэлтэс гэсэн 2 зохион байгуулалтын нэгжтэй байхаар баталсантай холбогдуулан хэлтсийн ахлах мэргэжилтний албан тушаалд Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 16 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албаны ерөнхий шалгалт өгөх болзол, журам”-ын хүрээнд 1 албан хаагчийг шатлан дэвшүүлэн томилж, “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”,-ын дагуу төрийн жинхэнэ албан тушаалын 1 сул орон тооны захиалгыг хүргүүлж, Төрийн албаны зөвлөлийн 14 дүгээр тогтоолын хүрээнд төрийн жинхэнэ албан тушаалд томилох ажлыг зохион байгуулсан.

3.1.6. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж байгууллагын жилийн төсөв, төсвийн гүйцэтгэл, төсвийн хэмнэлт, хэтрэлт, аудитын зөвлөмжийн тайлан, санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд тайлагнаж, тайлант хугацаанд үндсэн үйл ажиллагааны чиглэлээр 41, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны чиглэлээр 23, бусад чиглэлээр 33 буюу 97 ажлын мэдээллийг www.info.shilendans.gov.mn цахим санд оруулж ил тод байдлыг ханган ажилласан.

ТАНИЛЦСАН:

ДАРГА

Д.БАТСҮХ

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН

АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН

ГҮЙЦЭТГЭГЧ

Х.СОДНОМДЭМБЭРЭЛ

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:

ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, ТОГТООЛ

ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ ХАРИУЦСАН

МЭРГЭЖИЛТЭН

О.НЯМБАТ